

МОДУЛЬ
7

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХУЧИРХИЙЛЭЛ БА ХҮН
ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ



МОДУЛЬ 7

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар боловсруулсан: Гүнсэнчоймболын Амаржаргал

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон
Энхболдын Жаргал
Баяндалайн Баярмаа
Нямсүрэнгийн Онон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Хорлоогийн Балдандорж

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй НҮБ-ын "Итгэлцлийн Сан"-гийн санхүүжилттэй "Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь" төслийн хүрээнд боловсруулж, хэвлүүлэв.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org | Модулийг цахим хэлбэрээр www.savethechildren.mn вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс 2023 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.	7
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	8
НЭГ. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ НИЙГМИЙН ҮЗЭГДЭЛ БОЛОХ НЬ.	11
1.1. Жендэрт суурилсан хүчирхийллийн үндсэн ойлголт, төрөл, хэлбэр	12
1.2. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний тогтолцоо	25
ХОЁР. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ	34
2.1. Хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн зохицуулалт.	35
2.2. Хүн худалдаалах гэмт хэрэг ба эрүүгийн хууль.	40
2.3. Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал	45
2.4. Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс	55
2.5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ	60
ХАВСРАЛТ.	74
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалах чиглэлээр үйлчилж буй эрх зүйн актууд	74
Хүн худалдаалах гэмт хэрэг ба түүтэй төстэй гэмт хэргийн харьцуулалт	76
Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тодорхойлох жишиг маягт.	82
НОМ ЗҮЙ.	83

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хүндэтгэн хангах, хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын, бие даасан, хараат бус иргэний нийгмийн байгууллага юм. ХИС-гийн Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь НҮБ-ын Итгэлцлийн Сан (UN Trust Fund)-гийн санхүүжилтээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг гурван жилийн (2021-2024) хугацаатай, нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт хэрэгжүүлж байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, НҮБ-ын хороодын дүгнэлт зөвлөмжүүдэд охин хүүхдийг бэлгийн болон бусад төрлийн мөлжлөгөөс хамгаалж, хүчирхийллийн аливаа хэлбэрээс охидыг хамгаалах, нэр төрийг нь хүндэтгэхийг эрхэмлэх ёстойг онцлон тэмдэглэдэг. Монгол Улсад хүчирхийлэлтэй тэмцэхэд тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа хэдий ч жендэрт суурилсан хүчирхийлэл, охидын эсрэг хүчирхийллийн тоо буурахгүй хэвээр байгаад зовниж, Хүүхдийг Ивээх Сан охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилго тавин ажиллаж байна.

Төслийн хүрээнд бид хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэх зорилго бүхий 11 модулиас бүрдэх багц гарын авлагыг боловсруулан та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Тус гарын авлага нь хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын тогтолцоо, салбарын ажилтнуудын оролцоо, үүрэг, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндсэн ойлголт, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй (хохирогч/даван туулагчид ээлтэй) арга зүй, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээ, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ, кейс менежмент, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охидод үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, хүүхэд хамгааллын ажилтнуудын ажлаас халшрах хам шинжийн талаарх ойлголтыг өгч, хүүхдэд сэтгэцийн дам гэмтэл учруулахгүйгээр, цаг алдахгүй мэргэжлийн үйлчилгээг чанартай үзүүлэх үр чадварыг өсгөх зорилготой юм.

Олны хүч оломгүй далай гэдэг ээ.

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох, эрхээ ялгаварлалгүй эдэлдэг, хариуцлагатай нийгмийг цогцлоох үйлст хувь нэмрээ оруулж, сургалтын энэхүү багцын “Модуль 7. Жендэрт суурилсан хүчирхийлэл ба хүн худалдаалах гэмт хэрэг” хэсэгт гэрээлэн ажилласан эрдэмтэн, судлаач Гүнсэнчоймболын Амаржаргалд болон Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багтаа талархал илэрхийлье.

Энэ чиглэлээр бидний нэгэн адил хувь нэмэр оруулж, Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байгаа зорилго нэгт, хөгжлийн болон хүмүүнлэгийн бүх түншүүддээ талархал илэрхийлье.

Энхбатын Цолмон

ХИС-гийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер

Багц гарын авлагын 11 модуль тус бүрийн хоорондын уялдаа холбоо, зорилгыг доорх хүснэгтэд харууллаа.

Модулийн нэр	Зорилго
Модуль 1 Хүүхдийн эрх, хамгаалал ба хүүхэд хамгааллын бодлого	Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлага, хүүхдийн хамгаалагдах эрх, хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, бодлогын талаар онол, практик хэрэглээ, сайн туршлагыг танилцуулах
Модуль 2 Хүүхэд хамгааллын үйлчилгээ ба кейс менежмент	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх гэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин тус бүрд хамгааллын үйлчилгээ хүргэх, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээг хэрхэн хүргэх
Модуль 3 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байрны үйлчилгээ	Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байранд байрлаж буй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нас, сэтгэцийн онцлогт тохирсон үйлчилгээг хэрхэн үзүүлэх, үйлчилгээг стандартын дагуу сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй байдлаар үзүүлэхэд анхаарах асуудал, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд анхан шатны болон хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх
Модуль 4 Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ	Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ, үйлчилгээнд хамруулах хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын үнэлгээний талаар үндсэн ойлголттой болж, хувилбарт үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний төлөвлөлт хийхэд баримтлах зарчим, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулах
Модуль 5 Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн давуу талд тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээ, тэр дундаа нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар арга зүйн үндсэн ойлголт, онолын үндэслэлийн талаар мэдлэг нэмэгдүүлэх, мөн хүчирхэг болгох амьдрах ухааны ур чадварыг олгох нийгмийн ажлын арга зүй, хандлага зэрэг талаар мэдээлэл өгөх
Модуль 6 Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал	Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, хүүхдэд тохиолдох эрсдэл, үйлчилгээний зохион байгуулалт, удирдлага, кейс менежмент, урьдчилан сэргийлэлтийн талаар ойлголт өгөх.
Модуль 7 Хүн худалдаалах гэмт хэрэг ба жендэрт суурилсан хүчирхийлэл	Жендэрийн үндсэн ойлголт, түүний эрх зүйн зохицуулалт, үндэсний тогтолцоо, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний төрөл хэлбэр, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг илрүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар мэдлэг нэмэгдүүлэх

Модуль 8

Хүүхэд худалдаалах гэмт хэрэг-илрүүлэлтийн стратеги болон үйл явц

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, зохицуулалтын онцлог, хүүхдийг худалдаалж буй төрөл, хэлбэр, хохирогч хүүхдийг илрүүлэх, таньж мэдэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулах талаар нэгдсэн ойлголт өгөх

Модуль 9

Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагч төвтэй арга зүй

Сэтгэцийн гэмтлийн тухай ерөнхий ойлголт, төрөл, илрэх нийтлэг шинж тэмдэг, сэтгэцийн гэмтэл бие махбод, оюун санаа, сэтгэл хөдлөл, нийгмийн харилцаанд нөлөөлөх сөрөг нөлөө, дахин сэтгэцийн гэмтэлд урчлуулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах зүйлс, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зарчмуудын талаар ойлголт өгөх

Модуль 10

Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө хамгаалах нь

Ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинжийн ойлголт, үүсэх үе шат, нөлөөлөх хүчин зүйл тухай мэдлэг олгоно. Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжид өртөх шалтгаан, илрэх сөрөг үр дагавар, урьдчилан сэргийлэх сэтгэл зүйн бэлтгэх, ажлаас халшрах хам шинжийг үнэлэх аргачлал, түүнийг даван туулах сэтгэл зүйн заслын тусламжид суралцах болно.

Модуль 11

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагчдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинжүүд, хохирогч/даван туулагчдад илрэх сэтгэл зүйн болон бие махбодын шинжүүдийг ялган таньж мэдэх, сэтгэцийн гэмтлийн тухай ойлголт, төрөл, нөлөөлөх хүчин зүйлс, хүчтэй стресст өгөх цочмог хариу урвалын тухай ерөнхий ойлголт, гэмтлийн дараах стрессийн эмгэг, түүнд хэрэглэх сэтгэл зүйн зөвлөгөөний арга техникүүдийн талаар анхан шатны мэдээлэл өгөх

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХЯ	Гадаад хэргийн яам
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХЭЗБ	Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОУТББ	Олон улсын төрийн бус байгууллага
Палермогийн протокол	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Бэлгийн дарамт ¹	бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзолыг хэлнэ.
Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч ²	гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.
Гэр бүлийн хүчирхийлэл ³	хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг ⁴	хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд хуульд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг хэлнэ.
Жендэр ⁵	улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ.
Жендэрийн хэвшмэл үзэл ⁶	улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг хэлнэ.
Жендэрийн шууд бус ялгаварлан гадуурхалт ⁷	хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдлыг хэлнэ.
Жендэрийн шууд ялгаварлан гадуурхалт ⁸	бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг хэлнэ.
Жендэрийн эрх тэгш байдал ⁹	эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх байдлыг хэлнэ.

1 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2011. №8

2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

3 Мөн тэнд

4 Мөн тэнд

5 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2011. №8

6 Мөн тэнд

7 Мөн тэнд

8 Мөн тэнд

9 Мөн тэнд

Жендэрийн ялгаварлан гадуурхалт ¹⁰	улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.
Жендэрт суурилсан хүчирхийлэл ¹¹	жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.
Мөрдөгч ¹²	хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг хэлнэ.
Мөрдөн шалгах ажиллагаа ¹³	хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах энэ хуульд заасан ажиллагааг хэлнэ.
Мөрдөн шалгах нууц ажиллагаа ¹⁴	прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагааг хэлнэ.
Нийгмийн ажилтан ¹⁵	баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтанг хэлнэ.
Нэг цэгийн үйлчилгээ ¹⁶	хохилогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг хэлнэ.
Томилогдсон өмгөөлөгч ¹⁷	хуульд заасан тодорхой нөхцөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийг хэлнэ.
Түр хамгаалах байр ¹⁸	хохилогчийг тодорхой хугацаагаар байрлуулан энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг хэлнэ.
Хамгаалалтын арга хэмжээ ¹⁹	гэрч, хохилогчийн амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйг хамгаалах арга хэмжээг хэлнэ.
Хамтран амьдрагч ²⁰	гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийг хэлнэ.
Холбон зуучлах үйлчилгээ ²¹	гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохилогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээг хэлнэ.
Хохилогч ²²	эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохилогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ.

10 Мөн тэнд

11 Мөн тэнд

12 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №3

13 Мөн тэнд

14 Мөн тэнд

15 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016. №9

16 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

17 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №3

18 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

19 Гэрч, хохилогчийг хамгаалах тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2013, №30

20 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

21 Мөн тэнд

22 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 3 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2012. №7

Хууль зөрчсөн хүүхэд ²³	гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл зөрчил үйлдэж шийтгэгдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг хэлнэ.
Хүн худалдаалах ²⁴	хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ.
Хүүхдийн эрхийн ажилтан ²⁵	хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтныг хэлнэ.
Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо ²⁶	гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг хэлнэ.
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл ²⁷	санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ.
Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ ²⁸	эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг хэлнэ.
Хүчирхийллийн болзошгүй эрсдэл ²⁹	гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг хэлнэ.
Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд ³⁰	эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ³¹	гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ.

23 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016. №9

24 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 3 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2012. №7

25 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016. №9

26 Мөн тэнд

27 Мөн тэнд

28 Мөн тэнд

29 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

30 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016. №9

31 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №3

НЭГ

**ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЭЛ НИЙГМИЙН
ҮЗЭГДЭЛ БОЛОХ НЬ**

1.1

Жендэрт суурилсан хүчирхийллийн үндсэн ойлголт, төрөл, хэлбэр

1.2

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний тогтолцоо

1.1

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Хүн төрөлхтний аюулгүй байдал, хэвийн аж төрөх ёс, амгалан тайван байдалд аюул, эрсдэл учруулах аливаа үйл явдлаас сэргийлэн хамгаалах явдал нь төр, нийгэм, хувь хүний өмнө тулгамдсан амин чухал асуудлын нэг байсаар ирсэн. Газар хөдлөлт, гал түймэр, үер, ган, зуд зэрэг байгалийн гамшиг, түүнчлэн дайн, зэвсэгт мөргөлдөөн, гэмт халдлага зэрэг хүний хүчин зүйлээс шалтгаалах хүчирхийлэл, ослын зэрэгцээ халдварт өвчин, цар тахал, өлсгөлөн зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлийн хосолмол гарвал бүхий аюул нүүрлэж ирснийг түүх гэрчилнэ.

Эдгээр аюул занал нь хүн, нийгэм, төрийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, улс төр, эдийн засгийн тогтвортой байдалд урт болон богино хугацаанд сөргөөр нөлөөлж, нийгмийн сөрөг үзэгдлүүдийг байнга дагуулж байдаг тул тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нэгэнт тулгарсан аюулын сөрөг нөлөөг бууруулах, учирсан хохирол, хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, дахин өртөж хохирох явдлаас хамгаалахад чиглэсэн бодлого, хариу арга хэмжээг зөв төлөвлөн хэрэгжүүлэх нь аливаа нэг улс орны төдийгүй олон улсын хамтын хүчин чармайлтыг шаардсан ээдрээ төвөгтэй үйл явц юм. Гэвч урьдчилан сэргийлж, таслан зогсоож, хамгаалах боломжтой хүний хүчин зүйлсээс шалтгаалах аюулаас хүүхэд, өсвөр насны охид, хөвгүүдийг бүрэн хамгаалж чадахгүй байсаар байна. Хүчирхийллийн улмаас 7 минут тутам дэлхийн хаа нэгтээ өсвөр насны хүүхдийн амь нас хохирч³², жилд дунджаар нэг тэрбум гаруй хүүхэд ямар нэгэн байдлаар бие махбодийн, бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэл, үл хайхралд өртөж³³, 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд хамтран амьдрагчийн бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн хохирогч болж байна. Монгол Улсын хувьд гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртсөн. Эдгээр эмэгтэйчүүдийн 4 хүн тутмын 1 нь (26.5%) хэн нэгэнд хандаж, хэлж байгаагүй байна.³⁴

Хүчирхийлэл нь хүнийг хүсэл зоригийг нь үл харгалзан өөрийн эрхшээлдээ оруулахад чиглэсэн хүч хэрэглэсэн үйлдэл бөгөөд биеийн хүч ашиглахаас гадна нийгэм-эдийн засгийн болон сэтгэл зүйн дарамт үзүүлэх, албадах, айлган сүрдүүлэх, заналхийлэх зэрэг олон хэлбэрээр илрэх хүний жам ёсны эрхэд халдаж буй гэмт зан үйл юм. Хүчирхийлэгчийн хувьд хохирогчоос бие физиологийн эсхүл эрх мэдлийн хувьд ямагт давуу байдалтай байдаг. Энэхүү давуу байдал нь зөвхөн биеийн хүчний төдийгүй тодорхой шийдвэр гаргах, санаа бодлоо хэрэгжүүлэх боломж, чадварын тэгш бус байдлын хүлээн зөвшөөрөгдсөн илэрхийлэл гэж үздэг.

32 United Nations Children's Fund, A Familiar Face: Violence in the lives of children and adolescents, UNICEF, New York, 2017.

33 <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/violence-against-children>

34 "Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017" Үндэсний статистикийн хороо. УБ.,2018

Энэ шинжээс нь хамааран хүчирхийллийг дараах хэлбэрүүдэд ангилж болно. Үүнд: бие махбодийн хүч хэрэглэсэн; эдийн засгийн эрх мэдлээ ашигласан; улс төрийн эрх мэдлээ ашигласан; нийгэмд эзлэх байр сууриа ашигласан; жендэрт суурилсан³⁵ зэргээр ангилна.

Хүчирхийллийн эдгээр хэлбэрүүдээс жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн байр суурь, үнэлэмж, эрх мэдлийн тэнцвэрт бус байдлаас үүдэлтэй бөгөөд түгээмэл тохиолддог боловч цөөн мэдээлэгддэг³⁶ хүний аюулгүй байдалд заналхийлж буй нийгмийн сөрөг үзэгдлийн нэг мөн.

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь дараах үндсэн шинжтэй.

Нэг. Жендэрт суурилсан нийгэмд аюултай сөрөг зан үйлийн илрэл – Хүчирхийлэл ба жендэрийн ойлголт нь объектив болон субъектив байдлаар харилцан хамааралтай байх бөгөөд аль аль нь тэгш бус, ялгаатай байдлын харьцааг илэрхийлж байдаг нийгмийн үнэлэмж юм. Жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүний дүр төрх, эрх мэдэл, үүрэг хариуцлага, байр суурийн ялгаатай байдлын талаарх нийгмийн хүлээлт, үнэлэмжийг илэрхийлэх хэмжигдэхүүн бөгөөд нийгмийн хувьслыг даган өөрчлөгдөж байдаг. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгмийн ялгаатай байдлыг илэрхийлдэг бөгөөд хүйсийн ялгаатай байдалтай адилтган үзэж болохгүй. Хүйс нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгааг илэрхийлэх биологийн болон физиологийн шинжүүдийг илэрхийлэх бөгөөд ямарч үед хувьсан өөрчлөгдөх боломжгүй ялгааг илэрхийлдэг.

Жендэр нь нийгмийн анги давхраа, нас, арьсны өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газарзүй, эдийн засаг, улс төр, соёлын орчин гэх зэрэг олон үзүүлэлттэй харилцан хамааралтай бол хүйс нь хүний нөхөн үржихүйн тогтолцоотой хамааралтай байдаг. Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд зааснаар жендэр гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага³⁷ юм.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ энэ тэнцүү үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, адил оролцоотой байхыг жендэрийн тэгш байдал гэнэ. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст яг адилхан хандана гэсэн үг биш, харин нөхцөл байдал, боломж, бололцоог нь адил тэгш болгоход анхаарахыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил гэсэн үг биш, харин улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцөл бүрдсэнийг ойлгоно.

Жендэрийн тэгш бус байдал нь хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг үүсгэж, хүйсээс нь шалтгаалан боломж, бололцоог нь хязгаарлаж байдаг. Орлогын тэгш бус байдал, боловсролын тэгш бус байдал, жендэрийн тэгш бус байдал, хөрөнгийн тэгш бус байдал, эрх мэдлийн тэгш бус байдал гэх мэтээр тэгш бус байдал нь олон хэлбэртэй байдаг. Тэгш бус байдлын ойлголт нь ихэвчлэн сайн сайхан байдлыг орлогоор төлөөлүүлэн авч үздэг, “аж байдалд чиглэсэн” уламжлалт үзэл баримтлалыг голчилсон байдаг. Харин боломжид чиглэсэн үзэл баримтлалаар, “аж байдал”-д тухайн хүний төрсөн орчин нөхцөл ихээхэн нөлөөлдөг учраас аж байдлын

35 <https://www.unfpa.org/sites/default/files/pub-pdf/>

36 United Nations Children's Fund, A Familiar Face: Violence in the lives of children and adolescents, UNICEF, New York, 2017. Судалгаанд хамрагдсан 30 орны тоо баримтаас үзвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирсон өсвөр насны охидын нэг хувь нь энэ талаар мэдээлж, мэргэжлийн тусламж авсан байна.

37 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2011, №8

түвшин гэх мэт бусад хүчин зүйлээс хамаарахгүйгээр хүн бүрд “боломж”-ийг олж авах тэгш эрх өгөгдсөн байх ёстой гэж үздэг.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсд юу хийж болох, болохгүйг тулгаж, хүлээлт, шахалт үүсгэх, ялгаварлан гадуурхах зорилгоор үйлдэгддэг ба шалтгаан нь жендэрийн тэгш бус байдал юм.

Хоёр. Хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, эрх мэдэл, давуу байдлаа ашигласан идэвхитэй үйлдэл – Жендэрт суурилсан хүчирхийлэлд хэн ч өртөж болох ч ихэвчлэн охид, эмэгтэйчүүдийн эсрэг, эрэгтэйчүүд хүчний давуу байдлаа ашиглан үйлдэж, өөрийн хүрээлэн орчин дахь эрх мэдлийн давуу байдлаараа сүрдүүлэн хүчирхийлээ нуун далдалж, нуугдмал байдалд үргэлжлүүлэх санаа зорилго ямагт агуулж байдаг. Хүчирхийлэл үйлдэгч нь аль ч хүйсийн хүн байж болох хэдий ч энэ төрлийн хэргийн тоо баримтаас харахад ихэнх тохиолдолд эрэгтэйчүүд байна.

Зураг 1. Хүч хэрэглэсэн хүчирхийллийн арга



Энэ төрлийн хүчирхийлэл нь ихэнхдээ идэвхитэй үйлдлээр илрэх боловч зарим тохиолдолд үл хайхрах, ялгаварлан гадуурхах зэрэг эс үйлдэхгүйгээр илэрч болно.³⁸

Гурав. Жендэрт суурилсан хүчирхийлэл хувь хүнд төдийгүй нийгэмд тодорхой хор уршиг – Жендэрт суурилсан хүчирхийллийн улмаас олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор хамгаалагдсан хүний суурь эрхүүдэд халдаж хор уршиг учруулсан байдаг. Хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, халдашгүй, чөлөөтэй байх, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг хүний эрх, ашиг сонирхолд халдаж, хор уршиг учруулна. Хүчирхийлэлд өртөгч нь ихэнх тохиолдолд охид, эмэгтэйчүүд байх бөгөөд дараах хохирлыг учруулна.

- **Хүний амь нас хохирох:** Энэ хүчирхийллийн улмаас хохирогч нас барах, амиа хорлох, үр зулбах зэрэг ноцтой хохирол учирч болно.
- **Хүний биеийн эрүүл мэндэд хохирол учрах:** Хохирогчийн бие, эрхтэнд гэмтэл учрах, шарх үүсэх, тахир дутуу болох, халдварт өвчнөөр өвдөх зэрэг хүнд, хөнгөн хохирол учирна.

³⁸ Эс үйлдэхүй гэдэг нь хууль, гэрээ, дүрэм, журмаар хүлээсэн үүрээ гүйцэтгэхгүй байх, хийх ёстой үйлдэлээ хийхгүй байхыг ойлгоно.

- **Хүний сэтгэцийн эрүүл мэндэд хохирол учрах:** Хүчирхийллийн улмаас санаа сэтгэл цочрон давчдах, гүн цочролд орох, сэтгэцийн хэвийн ажиллагаа алдагдаж түр саатах, согтууруулах болон мансууруулах бодис, хорт зуршилд донтох
- **Эдийн хохирол учрах:** Хүчирхийллийн улмаас эд хөрөнгө эвдрэх, устгах, зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох, ирээдүйд олох орлого тасалдах гэх зэрэг.
- **Нийгмийн гадуурхал, доромжлолд өртөх, өөрийгөө тусгаарлах:** Энд учирч болох хор уршиг, хохирлын зарим жишээг дурьдсан бөгөөд бүрэн жагсаалт биш. Хохирогч бүр хувь хүн учраас хүчирхийллийн улмаас учирсан хор уршиг, үр дагавар харилцан адилгүй байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) гэдэг нь бусдыг хянах, эрх мэдлээ мэдрэхийн тулд хэн нэгнийг үгүйсгэх, хязгаарлах, хянах, дарамт шахалт үзүүлэх, заналхийлэх зэрэг ямар ч аргаар үйлдэгдэж болох ба зовиур шаналал, хор хохирол учруулах буюу учруулж болзошгүй санаатай үйлдэл, эс үйлдэхүй юм. Жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд нийгмээс оноосон үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурь, хүлээлтийг тодорхойлж, тэдний хувьд “зөв”, “зүйтэй” хэмээн тооцогдох зан үйл, юу хийж болох, болохгүйг тулгаж, хүлээлт, шахалт үүсгэдэг ба түүн дээр үндэслэн үйлдэгддэг учраас жендэрт суурилсан хүчирхийлэл гэж нэрлэгддэг. Жендэрт суурилсан хүчирхийлэл ялгаварлан гадуурхалд үндэслэгдсэн байдаг ба суурь шалтгаан нь жендэрээс үүдэлтэй эрх мэдлийн тэнцвэргүй байдал юм. Эрх мэдлийн тэнцвэргүй харилцаа суурь шалтгаан нь учраас ихэвчлэн эмэгтэйчүүд, охидын эсрэг үйлдэгддэг.


Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэжээ. Өөрөөр хэлбэл ялгаварлан гадуурхалт бол нийгмийн тодорхой бүлгийн гишүүнийх нь хувьд хүмүүстэй бусад хүмүүсийн адил эрх тэгш хандахгүй байх үйлдлийг хэлнэ.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэжээ. Өөрөөр хэлбэл ялгаварлан гадуурхалт бол нийгмийн тодорхой бүлгийн гишүүнийх нь хувьд хүмүүстэй бусад хүмүүсийн адил эрх тэгш хандахгүй байх үйлдлийг хэлнэ³⁹.

39 Б.Өнөрмаа, Ялгаварлан гадуурхалтын ойлголт, эрх зүйн зохицуулалт, www.mglbar.mn/news/4047

Зураг 2. Жендэрийн ялгаварлан гадуурхалтын хэлбэр



Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийллийн гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүчиндэх гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэрэг төрлүүд түгээмэл үйлдэгддэг. Эднээс гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах болон бэлгийн хүчирхийлэл, дарамт нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хамгийн хор хөнөөлтэй хэлбэрүүд байсаар байна.⁴⁰

Зураг 3. Жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэр

Жендэрт суурилсан хүчирхийлэл			
Гэр бүлийн хүчирхийлэл	Хүн худалдаалах гэмт хэрэг	Бэлгийн хүчирхийлэл	Ажлын байрны бэлгийн дарамт

Гэр бүлийн хүчирхийлэл

Монгол Улс хүн хоорондын гэрлэх, гэрлэлтээ дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцлийг тогтоох, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 1999 оны 06 дугаар сарын 11-ний өдөр анхны Гэр бүлийн тухай хуулийг УИХ-аас баталж, өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Уг хуульд зааснаар “гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг; “гэр бүл” гэдэг нь гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ⁴¹ гэж тодорхойлжээ.

Нийгэмд гэрлэсэн, урьд нь гэр бүлийн харилцаатай байсан, эсхүл хэзээ нэгэн цагт хамт амьдарч байсан бусад ойр дотны хүмүүсийн зүгээс хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор бие махбод, сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хэлбэрээр хяналтаа тогтоож, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус байдал газар авах хандлага нэгэнт бий болсон.

40 Жендэрийн үндэсний хороо, “Жендэр ба бодлого төлөвлөлт” Модуль сургалт 1-Жендэрийн сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ.,2018, 58 дахь тал

41 Гэр бүлийн тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэг, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,1999, №30

Ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдал түгээмэл болсон нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэхийг шаардаж байв.

Энэ ч хүрээнд УИХ-аас 2004 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” бие даасан хуулийг баталж, 2007 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим заавар, журмуудыг батлан хэрэгжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын Засгийн газраас хохирогчдыг хамгаалан байрлуулах, утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэшсэн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулан үйлчилгээ үзүүлж эхэлсэн зэрэг бодлого болон үйл ажиллагааны хүрээнд нааштай алхмууд хийгджээ.

Гэвч гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах зарчимд нийцүүлэн шинэтгэх шаардлагатай гэж үзэн УИХ-аас 2016 оны 12 сарын 22-ны өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход чиглэгдсэн.

Хуульд зааснаар гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэж эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд⁴² хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүй⁴³-г хэлнэ.

Хүснэгт 1. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

Бие махбодын хүчирхийлэл	хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй
Сэтгэл санааны хүчирхийлэл	хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг
Эдийн засгийн хүчирхийлэл	хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдал оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг
Бэлгийн хүчирхийлэл	эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадах

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар 30 орчим журам, стандартыг холбогдох байгууллага, албан тушаалтнууд баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна (Хавсралт №1).

42 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 3-р зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №5

43 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5-р зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №5

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид дараах үйлчилгээг үзүүлэхээр хуульчилсан байна.⁴⁴
Үүнд:

Зураг 4. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл



Аюулгүй
байдлын
хамгаалалт



Эмнэлэгийн
тусламж,
үйлчилгээ



Сэтгэл
зүйн
үйлчилгээ



Нийгмийн
халамжийн
үйлчилгээ



Хүүхэд
хамгааллын
үйлчилгээ



Холбон
зуучлах
үйлчилгээ



Дээрх үйлчилгээний талаарх ойлголт, үйлчилгээ үзүүлэх журмын талаарх мэдээллийн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33-42 дугаар зүйл болон хавсралт №1-т дурдсан журмуудаас дэлгэрүүлэн үзэх боломжтой.

Ажлын байрны бэлгийн дарамт

Олон улсын түвшинд ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх асуудлыг хурцаар шүүмжилж, хүний эрхийн ноцтой зөрчилд тооцож байгаа бөгөөд 2019 онд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас Хүчирхийлэл, дарамтын тухай 190 дүгээр Конвенцыг батлан гаргасан юм. Тус конвенцод Монгол Улс нэгдэн ороогүй байгаа хэдий ч 2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд бэлгийн дарамтын талаарх ойлголт, тодорхойлолтыг тусгасан бөгөөд 11 дүгээр зүйлд хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаарх ажил олгогч болон ажилтны эрх, үүргийг хуульчилсан.⁴⁵

Ажлын байрны бэлгийн дарамт нь хүний эрхийг зөрчиж, чимээгүй үйлдэгддэг гэмт хэрэг болохыг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч 130 гаруй орон хууль тогтоомжоо шинэчлэн мөрдсөн байна. Улс орон бүрд тухайн үйлдэл, эс үйлдлийг харилцан адилгүй байдлаар тодорхойлсон байдаг ч нийтлэг байдлаар гурван төрлийн хүрээнд тодорхойлжээ. Үүнд:

1. Эрэгтэй, эмэгтэй хүний бэлгийн болон түүнтэй холбоо бүхий бусад харилцаа хэн нэгний нь дур хүслээс гадуур, ёс бусаар, нэр төр, эрх чөлөөнд нь халдаж, хүч түрэмгийлэх, хохироох байдалтай үйлдэгдсэн бол;
2. Хэрвээ ийм үйлдлийн талаарх холбогдогчийн тайлбар, хохирогчийн нэхэмжлэл, асуудлыг шүүн хэлэлцсэн байдал, татгалзсан, зөвшөөрсөн аль нь ч байлаа гэсэн хохирогчийн ажил төрөлд сөрөг үйлчлэлтэй шийдвэр гаргахад ил болон далд байдлаар үндэслэл болж нөлөөлсөн бол;
3. Хохирогчийн нэр төрийг гутааж, хамт олны дунд үг хэлээр дайрах, доромжлох, гадуурхах зэргээр дарамтлах үр дагавар үүссэн бол.⁴⁶

Манай улс 2011 онд баталсан Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд анх удаа бэлгийн дарамтын талаарх ойлголтыг тусгасан бөгөөд хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь хэсэгт **бэлгийн дарамт** гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас

44 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 33-р зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №5

45 Жендэрийн үндэсний хороо, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргагүйн зөвлөмж, УБ.,2020, 5 дахь тал

46 Жендэрийн үндэсний хороо, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргагүйн зөвлөмж, УБ.,2020, 30 дахь тал

ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавихыг хэлнэ гэж заасан.

Мөн УИХ-аас 2021 онд баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 5 дугаар зүйлд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох зарчмыг баримтлахаар заасан. дараах суурь зарчмыг баримтална гэжээ. Мөн хуулийн 7 дугаар зүйлд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглохтой дараах асуудлыг зохицуулсан байна. Үүнд:

- ✓ Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ үгээр, биеэр, цахимаар болон бусад аливаа хэлбэрээр дараах байдлаар дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно;
- ✓ зодох, цохих зэргээр бусдын эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, үйлдэхээр заналхийлэх;
- ✓ хэл амаар доромжлох, нэр төр, алдар хүндийг гутаах;
- ✓ ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл зүйн дарамт, бэлгийн дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх замаар ажлын байрны тэвчишгүй орчныг үүсгэх.

Мөн ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үгээр, биеэр, цахимаар болон бусад хэлбэрээр илэрхийлэх, бэлгийн харилцаанд орох эсэхээс шалтгаалж ажил, албан тушаал, цалин хөлс зэрэг эдийн засгийн болон бусад байдлаар урамшуулах, эсхүл хохироохоор айлган сүрдүүлэх, тулган шаардах, болзол тавих (*quid pro quo*) байдлаар бэлгийн дарамт үзүүлэхийг хориглосон байна.

Түүнчлэн энэ тохиолдолуудад дарамт, хүчирхийлэлд өртөгч нь холбогдох эрх бүхий этгээдэд гомдлоо гарган шийдвэрлүүлэх боломжтой болгожээ.

Монголын эмэгтэйчүүдийн сангаас 2016 онд хийсэн онлайн Тандалтын судалгааны үр дүнгээс харахад ажлын байран дахь бэлгийн дарамтлалд өртөгсдийн 98 хувийг эмэгтэйчүүд эзэлж байхад, үйлдэгчдийн 97.5 хувийг эрэгтэйчүүд үйлдсэн бөгөөд тэдний 88,2 хувь нь дээд боловсролтой, 69.2 хувь нь удирдах албан тушаалтнууд байна гэжээ. Түүнчлэн тус сангаас 2018 онд хийсэн “Охид, эмэгтэйчүүдийн ажлын байран дахь бэлгийн дарамтын төлөв байдал, хандлага 2004, 2017 оны харьцуулсан судалгаа”-ны дүнгээс харахад 5 хүн тутмын нэг нь ажлын байрны бэлгийн дарамтанд өртдөг, 3 хүн тутмын нэг нь өртсөн хэн нэгнийг мэддэг гэж хариулсан байгаа нь энэ төрлийн дарамт шахалт буурахгүй байгааг харуулж байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах

1. Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сүргалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
2. Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

УИХ-аас баталсан Зөрчлийн тухай хуульд 2020 оны 01 сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар орсон нэг онцлог нэмэлт нь Бэлгийн дарамт учруулах үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.⁴⁷

Бэлгийн хүчирхийлэл

Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хүнийг өөрийн эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ⁴⁸. Бэлгийн хүчирхийлэл нь бэлгийн шинжтэй өдөөлт болон үйлдлээр нөгөө хүнийхээ халдашгүй байдлыг эвдэх оролдлого бөгөөд бэлгийн халдлага, хүчин, цус ойртолт, хүчээр биеийг нь үнэлүүлэх, мөн бэлгийн дарамт зэрэг сэтгэл санааны хүчирхийллийн хэлбэрээр ч илэрдэг байна.

Нэр томьёо, тодорхойлолт, журам, бодлого, шүүхийн шийдвэр улс орон бүрд бага зэрэг ялгаатай байж болох ч дараах ерөнхий ойлголтуудыг багтаасан байдаг. Үүнд:

- ✔ Хүчин гэдэг нь ихэнх улсын хууль тогтоомжид: бие махбодын хүчирхийллээр үйлдэгдсэн бэлгийн харилцаа эсвэл үтрээ, анус руу эр бэлэг эрхтэн, бусад эд зүйлсийг хүчээр оруулсан үйлдлийг хэлнэ хэмээн тусгасан байдаг. Ингэхээр оролдсон үйлдлийг хүчиндэх оролдлого хэмээн үздэг. Хоёроос олон хүчирхийлэгч оролцсон бол бүлэглэн хүчиндсэн хэрэг гэж үзнэ. Дайн тулааны бүс нутагт бэлгийн хүчирхийллийг дайны зэвсэг болгон ашигладаг бөгөөд ихэвчлэн охид, эмэгтэйчүүд хохирогч нь болдог байна.
- ✔ Бэлгийн халдлага гэдэг нь хохирогчийн хүсээгүй нөхцөлд бие махбодод нь хүрэх, бэлгийн сэдэлтэй үйлдэл хийх зэрэг орно. Гол төлөв хүчээр бэлгийн харилцаанд оруулах, бэлгийн гаж хавьталд хүчээр татан оруулах (шулуун гэдсээр болон амаар), хүүхэд хүчирхийлэх, гэр бүлийнхэнтэйгээ бэлгийн харилцаанд орохыг тулгах, хүчирхийлэхийг оролдох зэргээр илэрдэг.
- ✔ Бэлгийн дарамт нь хүсээгүй байхад нь тухайн хүний нэр хүндэд халдсан бэлгийн сэдэлтэй үйлдэл гаргах явдал бөгөөд бие махбодоор, үг хэлээр, үгэн бус байдлаар илэрдэг. Үүнээс ажлын байранд тохиолддог хамгийн түгээмэл хоёр төрөл нь:
 - Сүрдүүлэг: ажлын байранд нь ямар нэгэн хөнгөлөлт үзүүлнэ хэмээн амлаж бэлгийн хавьталд орохыг шаардах (ихэвчлэн дарга, ажил олгогч, ээлжийн ахлагч, хамтран ажиллагч, үйлчлүүлэгч г.м.)
 - Дайсагнасан ажлын байр: үг хэлээр, үгэн бус хэлбэрээр, биеийн хэлэмжээр бэлгийн өдөөлт хийж, ажлын байранд дээрэлхэж доромжилсон, дорд үзсэн, хорлонтой нөхцөл байдлыг үүсгэдэг.

Бэлгийн хүчирхийллийн олон хэлбэр бий. Ихэвчлэн жирийн тохиолдлууд мэт эхэлдэг ч ямар нэгэн арга хэмжээ авахгүй өнгөрүүлсээр байвал улам даамжирдаг.

Хэл амаар хүчирхийлэх:

бэлгийн шинжтэй онигоо ярих, хүний хувийн амьдрал, гадаад төрх, биеийн галбирын талаар хүлээн зөвшөөрч боломгүй яриа өдөөх, хүйсээр нь доромжлох

Дохио зангаагаар дарамтлах:

дохих, нүд ирмэх, гараар зангах, хөл, хуруу, гар, уруулаар бэлгийн сэдэлтэй хөдөлгөөн үзүүлэх

Бичгээр дарамтлах:

порно зураг үзүүлэх, э-шуудан явуулах, хүсээгүй байхад нь хайрын захиа илгээх

Сэтгэл зүйн дарамт:

ичгүүртэй байдалд оруулах, бусдаас тусгаарлах, хүйсээр нь ялгаварлан гадуурхах

47 Ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Жендэрийн үндэсний хорооны эрхлэн гаргасан АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ-өөс харна уу. <http://nsug.ub.gov.mn/pdf/belgiin%20daramt%202020.pdf>

48 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 6 дугаар зүйл

Бие махбодын хүчирхийлэл:

үнсэх, илэх, чимхэх, шалиг байдлаар биед хүрэх, бэлгийн халдлага хийх, хүчиндэх г.м.

Эдийн засгийн дарамт:

ямар нэгэн түслэмж үзүүлнэ хэмээн бэлгийн харилцаанд орохыг шаардах, эсэргүүцсэн тохиолдолд ажилгүй болгохоор сүрдүүлэх

Манай улсын тухайд Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцсон⁴⁹. Үүнд:

Хүснэгт 2. Эрүүгийн хууль дахь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх		
Үндсэн шинж	Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн	Нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж; - бүлэглэж; - гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж; - хохирогчийг жирэмсэн болгож; - хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж; - хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж; - урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; - харгис хэрцгий аргаар; - бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж; - хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн 	Таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
	<ul style="list-style-type: none"> - ураг зулбасан, - арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; - гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн 	Найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
	<ul style="list-style-type: none"> - бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; - энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан 	Арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.
<p>Тайлбар: Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсэн аль ч хүйсийн хүн байж болно.</p> <ul style="list-style-type: none"> - Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй. - “Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно. 		

49 Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2015, №7

12.2 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах

Үндсэн шинж	Хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан нь хүчиндэх гэмт хэргийн шинжгүй бол	Зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	Энэ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн	Нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн	Хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
<i>Тайлбар: Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн хохирогч нь аль ч хүйсийн хүн байж болно.</i>		

12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг

Үндсэн шинж	Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан	Нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж; - урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; - хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж; - хохирогчийг жирэмсэн болгож; - хоёр, түүнээс олон хүний эсрэг; - байнга тогтвортой үйлдсэн 	Хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - ураг зулбасан; - арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон 	таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - бага насны хүүхдийг албадан оруулж; - зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн 	арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ
<i>Тайлбар: Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</i>		

12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох

Үндсэн шинж	Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон	Дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - хохирогчийг жирэмсэн болгосон; - бэлгийн замын халдварт өвчин халдаасан 	Зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

12.6 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах

Үндсэн шинж	Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан	Зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	- Биеэ үнэлэх газар байгуулсан, - санхүүжүүлсэн, - биеэ үнэлэхийг зохион байгуулсан, - биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан	Нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	- Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	Таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
<i>Тайлбар: Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна.</i>		

Хүн худалдаалах гэмт хэрэг

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд уг гэмт хэргийг хар тамхи, мансууруулах бодис худалдах, тээвэрлэх, мөнгө угаах зэрэг гэмт хэрэгтэй хавсран үйлдэж ихээхэн хэмжээний ашиг орлого олдог хууль бус бизнес болон өргөжиж байгаа нь дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудал болоод байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудын орлого багатай, боловсролын түвшин доогуур, эмзэг бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүд байдаг бөгөөд тухайн орны эдийн засгийн хөгжил доогуур, иргэдийн эрх зүйн мэдлэг муу байгаа зэрэг нь энэхүү гэмт хэргийн хохирогч болох гол хүчин зүйл болж байна⁵⁰.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албанаас гаргасан тайланд дурдсанаар хүн худалдаалах гэмт хэргийн улмаас 137 орны 2,4 сая иргэн (хохирогч) хохирсон байдаг бөгөөд хохирогчдын 75 хувийг охид, эмэгтэйчүүд эзэлж байна. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг тархацаар нь авч үзвэл 1,000 хүн тутмын 1,8 нь ямар нэг байдлаар энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох, харин Ази Номхон далайн бүс нутагт 1,000 хүн тутмын 3 нь хохирогч болох эрсдэлтэй байгаа гэсэн үзүүлэлт гарсан байна.

Монгол Улс 2002 онд баталсан Эрүүгийн хуульд анх удаа хүн хулгайлах, хүн худалдах, худалдан авах, хүний цус, эд эрхтэнг хууль бусаар авах гэмт хэргийг хуульчилсан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдэх эхлэл тавигдсан. Засгийн газраас 2005 онд “Хүн, ялангуяа эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, энэ чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зөв ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаанууд хийгдсэн байна. Улмаар 2008 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орж, 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр үйлд Хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4.2-т “хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой

50 Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, УБ.,2017

холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгож энэ чиглэлд бэхжүүлнэ” гэж заасны дагуу 2011 онд Улсын Их Хурлаас хүн худалдаалахтай тэмцэх бие даасан хуулийг баталсан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагуудын хүлээх үүргийг тодорхой болгож, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах арга хэлбэр, хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилт зэргийг хуульчилсан болно.

Хүн худалдаалах гэмт хэрэг хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахууль өгөх зэрэг аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулан хүлээн авсан хууль бус үйлдлээр илэрдэг.

Хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн нөхцөл байдлын хувьд Монгол Улс нь хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор үндэстэн дамнасан ХХГХ-ийн илгээгч, хүлээн авагч, дамжуулагч орны тоонд багтаж байна⁵¹.

Тодруулбал, АНУ-ын Элчин сайдын яамны 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд дурдсанаар сүүлийн 5 жилийн хугацаанд тайлагнасанчлан хүн худалдаалах гэмт хэрэгтнүүд Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоод, гадаадын хохирогчдыг мөлжиж, мөн хилийн чанадад монголчуудыг мөлжлөгт оруулж байна. Гэмт этгээдүүд албадан хөдөлмөр эрхлэлт болон бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон гадаад иргэдийг Монгол Улсаар дамжуулан Орос, Хятад зэрэг улс руу худалдаалдаг байж болзошгүй байна. Монголын эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхээр Хятад, Энэтхэг, Казакстан, Норвеги, Швед, Турк болон Арабын Нэгдсэн Эмират улсуудад, харин бэлгийн мөлжлөгт ашиглахаар Бельги, Камбож, Хятад, Герман, Хонконг, Япон, Макао, Малайз, Филлипин, Өмнөд Солонгос, Швед, Турк, АНУ руу болон Монголд дотооддоо худалдаж байна. Хүний наймаачид зарим үед хар тамхи, олон нийтийн хуурамч сүлжээ, ажлын байрны цахим зар, англи хэлний хөтөлбөр зэргийг ашиглан хохирогчдыг хууран мэхлэх замаар бэлгийн мөлжлөгт татан оруулдаг ажээ.

Манай улсын тухайд тогтмол бус орлоготой эсвэл шилжиж очсон газартаа бүртгэлгүй, улирлын чанартай цагийн ажил эрхэлдэг оюутнууд, ажил хайж байгаа хүмүүс зэрэг 18-30 насны эрэгтэй болон эмэгтэй хүмүүс (Цагдаагийн Ерөнхий Газарт бүртгэгдсэн ХХГХ-ийн хохирогчдын профайлыг авч үзвэл 14 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүд өндөр эрсдэлтэй байгаа хэдий ч судалгааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан уг судалгаанд 18-аас доош насны иргэдийг хамруулаагүй болно) ХХГХ-т өртөх эрсдэлтэй байна. Эрсдэлтэй хүмүүс ихэвчлэн амьдралынхаа туршид бие махбодын болон сэтгэл зүйн хүндрэл, бэрхшээлтэй асуудалтай тулгарч байсан, салсан эсвэл ганц бие хүмүүс байна⁵².

ХХГХ-т өртөх эрсдэлтэй эдгээр хүмүүс ихэвчлэн гэр бүлийн хүчирхийллийн гэрч буюу хохирогч болж байсан өгүүлэмжтэй байх бөгөөд өрхийн аль нэг гишүүн нь удаан хугацаагаар ажил хийх, суралцах зорилгоор шилжин суурьшсан байх тохиолдол түгээмэл. Тэдний ихэнх нь орлого бага, санхүүгийн чадавх сул гэр бүлээс гаралтай байх боловч санхүүгийн чадавх сайтай гэр бүлд төрж өссөн хэдий ч гэр бүлийн хүчирхийлэлтэй байх, нийгэм хамт олны нэгдмэл байдал бага мэдэрдэг байх, эдийн засгийн боломж, баталгааг мэдрэхгүй байх зэрэг бусад гэр бүлийн болон бүтцийн хүчин зүйлээс үүдэн эмзэг байдал нь нэмэгдэж байна⁵³.

51 <https://mn.usembassy.gov/mn/2021-trafficking-in-persons-report-mn/>

52 НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, УБ.,2021

53 Мөн тэнд

1.2

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид НҮБ гэх/-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 70/1 тогтоолоор батлагдсан “Эх дэлхийгээ шинэчилье: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030” бодлогын баримт бичигт “...Шударга, эрх тэгш, хүлцэлтэй, нээлттэй, нийгмийн оролцоог хангасан, хамгийн эмзэг бүлгийнхний хэрэгцээг харгалзсан дэлхий ертөнцтэй болохыг зорьж байна. ...Бид хамтын энэ агуу аянд мордохдоо хэнийг ч орхигдуулахгүй гэдгээ андгайлж байна” гэж тунхагласан байдаг.

Үндэсний хэмжээнд жендэрийн тэгш байдлыг хангах нь дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах бодит арга хэрэгсэл болж байна.

Монгол Улс жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр олон улсын гэрээ, конвенцод нэгдэж, хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хууль тогтоомжоо шинэчлэх, шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр хүчин чармайлт гаргаж ажиллаж байна. Тухайлбал, манай улс олон улсын дараах гэрээ, конвенцод нэгдэн орсон байна. Үүнд:

Хүснэгт 3. Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц

№	Нэр	Батлагдсан	Хүчин төгөлдөр болсон	Монгол Улс нэгдэн орсон
1.	Хүний эрхийн түгээмэл тунхаглал ⁵⁴	1945.06.26	1945.10.24	1961.10.27
2.	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт ⁵⁵	1966.12.16	1976.01.03	
3.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт ⁵⁶	1966.12.16	1976.03.23	1978.11.18
4.	Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц ⁵⁷	1952.12.20	1954.07.07	
5.	Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111 дүгээр зөвлөмж ⁵⁸	1958.06.04		
6.	Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай конвенц ⁵⁹	1960.12.14	1962.05.22	
7.	Тэгш шан, хөлс олгох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц ⁶⁰	1951.06.29	1953.05.23	

54 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1271>

55 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1284>

56 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1257>

57 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1288>

58 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1184>

59 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1186>

60 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1189>

8.	Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц ⁶¹	1958.06.25	1960.06.15	
9.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц ⁶²	1979.12.18	1981.09.03	1981.07.20
10.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт ⁶³	1979.12.18	1981.09.03	1997.10.03
11.	Хүүхдийн эрхийн тухай конвенц ⁶⁴	1989.11.20	1990.09.02	1990.01.26
12.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1999.12.10	2000.12.22	20001.12.14
13.	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол ⁶⁵	2000.05.25	2002.01.18	2001.11.12
14.	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ⁶⁶	2000.11.15	2003.09.29	2008.05.16
15.	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол ⁶⁷	2000.11.15	2003.12.25	2008.05.16
16.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц ⁶⁸	2006.12.13		2008.12.19
17.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол ⁶⁹	2006.12.13		2008.12.19

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолоор “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-ыг батлагдсан. Дээрх олон улсын гэрээ, конвенцоос Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний протокол, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протоколын хэрэгжилтийн тайланг эрх бүхий байгууллагууд гаргахаар зохицуулагдсан байна⁷⁰.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх талаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, үндэсний эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хууль, тэдгээрийн агуулгын талаар товч авч үзвэл:

61 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1185>

62 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1285>

63 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1286>

64 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1276>

65 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1274>

66 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10028>

67 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10028>

68 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10034>

69 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10035>

70 Олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн тайлан, үнэлгээ болон ТББ-уудын сүүдэр илтгэлтэй цахим хэлбэрээр танилцах боломжтой.

https://tbinternet.ohchr.org/Treaties/CEDAW/Shared%20Documents/MNG/INT_CEDAW_NGO_MNG_23100_O.pdf

https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_615935.pdf

Хүснэгт 4. Жендэрийн тэгш байдлын талаарх үндэсний хууль тогтоомж дахь агуулга

Хууль тогтоомж	Агуулга
Монгол Улсын Үндсэн хуул ⁷¹	<p>14 дүгээр зүйл 2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.</p> <p>16 дугаар зүйл. 11.улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;</p>
Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль ⁷²	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>5 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлого 5.1.Жендэрийн эрх тэгш байдал дараахь үндсэн зарчимд тулгуурлана: 5.1.1.жендэрийн тэгш эрхийн зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах; 5.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх; 5.1.3.төрийн хариуцлагын зарчим: төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх; 5.1.4.жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим: хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох; 5.1.5.жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим: хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах. 5.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэнэ.</p>
Гэр бүлийн тухай хууль ⁷³	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцлийг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>

71 Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,1992, №1

72 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2011, №8

73 Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,1999, №30

<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль⁷⁴</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.</p> <p>6 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр 6.1.Энэ хуульд заасан дараахь үйлдлийг гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр гэж үзнэ: 6.1.1.бие махбодын хүчирхийлэл; 6.1.2.сэтгэл санааны хүчирхийлэл; 6.1.3.эдийн засгийн хүчирхийлэл; 6.1.4.бэлгийн хүчирхийлэл. 6.2.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг бие махбодын хүчирхийлэл гэнэ. 6.3.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ. 6.4.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ. 6.5.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ.</p>
<p>Хөдөлмөрийн тухай хууль⁷⁵ /шинэчилсэн найруулга/</p>	<p>5 дугаар зүйл. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны суурь зарчим, үндсэн эрх 5.1.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч дараах суурь зарчмыг баримталж, холбогдох үндсэн эрхийг эдэлнэ: 5.1.1.үл ялгаварлан гадуурхах; 5.1.3.дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох; 5.1.4.албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох; 5.1.9.хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах.</p> <p>6 дугаар зүйл.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглох 6.1.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно.</p>

74 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №5

75 Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2021, №31

6.2."Шууд ялгаварлан гадуурхалт" гэж энэ хуулийн 6.1-д заасан үндэслэлээр ялгаа, давуу байдал тогтоосон аливаа шийдвэр, үйлдлийг; "шууд бус ялгаварлан гадуурхалт" гэж хүн бүрд адил тэгш үйлчлэхээр заасан боловч хэрэгжилтийн явцад энэ хуулийн 6.1-д заасан үндэслэлээр хувь хүн, эсхүл бүлэг хүнийг ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал тогтоосноор тэгш байдал, боломжийг нь алдагдуулахад хүргэж байгаа аливаа шийдвэр, үйлдлийг тус тус ойлгоно.

6.3.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцөлийг ажил олгогч бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд дараах тохиолдлыг ялгаварласан, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон гэж үзэхгүй:

6.3.1.тухайн ажил үүргийн онцлогоос бий болгосон ялгаа, хязгаарлалт, давуу байдал;

6.3.2.энэ хуульд заасан зарим бүлгийн ажилтанд үзүүлэх хамгаалалтын тусгай арга хэмжээ, дэмжлэг.

6.4. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсэх, ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад ажил олгогч нь ажил үүрэгтэй нь холбогдолгүй аливаа асуулт асуух, мэдээлэл цуглуулах, хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд эрүүл мэндийн болон сэтгэцийн эмгэг, хүний дархлал хомсдолын вирусийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгүүлэх, жирэмсэн эсэхийг тодруулахыг хориглоно.

7 дугаар зүйл.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох

7.1.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ үгээр, биеэр, цахимаар болон бусад аливаа хэлбэрээр дараах байдлаар дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно:

7.1.1.зодох, цохих зэргээр бусдын эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, үйлдэхээр заналхийлэх;

7.1.2.хэл амаар доромжлох, нэр төр, алдар хүндийг гутаах;

7.1.3.энэ хуулийн 6.1-д заасан хориглосон үндэслэлээр ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл зүйн дарамт, бэлгийн дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх замаар ажлын байрны тэвчишгүй орчныг үүсгэх.

7.2.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үгээр, биеэр, цахимаар болон бусад хэлбэрээр илэрхийлэх, бэлгийн харилцаанд орох эсэхээс шалтгаалж ажил, албан тушаал, цалин хөлс зэрэг эдийн засгийн болон бусад байдлаар урамшуулах, эсхүл хохироохоор айлган сүрдүүлэх, тулган шаардах, болзол тавих /quid pro quo/ байдлаар бэлгийн дарамт үзүүлэхийг хориглоно.

7.4.Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх үүрэгтэй.

8 дугаар зүйл.Албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох

8.1.Хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэхийг хориглоно.

8.2."Албадан хөдөлмөрлүүлэх" гэж аливаа торгууль, шийтгэл ногдуулахаар айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг ажил, үйлчилгээ эрхлүүлэхийг ойлгоно.

<p>Төрийн албаны тухай хууль⁷⁶ /шинэчилсэн найруулга/</p>	<p>37.1.Төрийн албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 37.1.12.Төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх; 39.1.Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно; 39.1.4. Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэх;</p>
<p>Зөрчлийн тухай хууль⁷⁷</p>	<p>5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: 4.1.зодсон; 4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; 4.3.бусадтай харилцахыг хязгаарласан; 4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна. 6.18 дугаар зүйл.Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих 4.Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих 1.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хуулиар асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд: 1.1.хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан; 1.2.хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг хэрэглүүлсэн; 1.3.хүүхдийг дархлаажуулалтад хамруулах үүргээ биелүүлээгүй; 1.4.хуулиар хүлээсэн асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 7.Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 8.Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдэгдэх, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>6.26 дугаар зүйл.Бэлгийн дарамт учруулах 1.Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.</p>

76 Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2018, №5

77 Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №41

	2.Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
Эрүүгийн хууль ⁷⁸ /шинэчилсэн найруулга/	11.7 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 12.1 дүгээр зүйл.Хүчиндэх 12.2 дугаар зүйл.Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 12.3 дугаар зүйл.Бэлгийн мөлжлөг 12.5 дугаар зүйл.Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 12.6 дугаар зүйл.Биеэ үнэлэхийг зохион байгуулах 13.1 дүгээр зүйл.Хүн худалдаалах 14.1 дүгээр зүйл.Ялгаварлан гадуурхах
Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль ⁷⁹	3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.“хүн худалдаалах” гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг;

Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад манай улс 1990 оноос хуулийн шинэ орчинг бүрдүүлж эхэлсэн. Тухайлбал 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд эрэгтэй, эмэгтэй бүхий л иргэн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэйг баталгаажуулан хуульчилсан.

Түүнчлэн, ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүн, өндөр настанг асрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох эрхийг нь хуульчилсан юм. Төрийн байгууллага, холбогдох яамд 1992-1995 онд эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах асуудал болон “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан ажиллаж байв. Жендэрийн тэгш байдлын асуудал хариуцах Үндэсний зөвлөлийг 2000 онд байгуулж, 2005 он хүртэл “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Тус зөвлөл 2005 оноос Жендэрийн тэгш байдлын Үндэсний Хороо болон өргөжиж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого хэрэгжүүлэхэд төр, олон нийтийн тэнцүү оролцоог хангах, “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, хяналт-үнэлгээ хийх үйл ажиллагааг хариуцан ажиллаж байжээ.

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулиар Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчдийг сонгон шалгаруулахад жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах үүрэг, хариуцлагыг ногдуулсан байдаг бол Хүний Эрхийн Үндэсний Комисст Үндсэн хууль болон бусад хуульд орсон жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн зүйл, заалтын хэрэгжилтэд хяналт тавих эрхийг олгосон.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль нь Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхий сайд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг

78 Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016, №21

79 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2012, №7

ханган ажиллах шаардлага тавьсан байна. Мөн түүнчлэн Жендэрийн Үндэсний Хороо, төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгсөн.

Иргэний нийгэм болон ТББ-уудын үүрэг оролцоог мөн энэ хуульд дараах байдлаар онцолсон байдаг.


- жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого, бусад шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавихад оролцох, иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах;
- төрийн байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой мэдээлэл, санхүү, арга зүйн болон бусад дэмжлэг авах;
- жендэрийн эрх тэгш байдлын талаар саналаа илэрхийлэх.

Жендэрийн харилцаа нь нийгмийн амьдралын бүх салбар, чиглэлийг хамардаг тул жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо нь салбар болон нийгмийн оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах чадамжтай байхыг дэлхий нийтээр даган мөрддөг Бээжингийн мөрийн хөтөлбөрт чухалчлан заасан байдаг.

Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлсэн, Жендэрийн үндэсний хороо нь ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн 8 яамны Төрийн нарийн бичгийн дарга, төрийн бусад (8) болон төрийн бус (12) нийт 28 байгууллагын төлөөллийг багтаасан салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан зөвлөх чиг үүрэг бүхий дэлхийн тэргүүн туршлагын жишээ юм.

Жендэрийн үндэсний хороо нь 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт 31 салбар хороо, төрийн захиргааны 14 төв байгууллага (яамд)-д салбар зөвлөлтэй, Хорооны Ажлын алба нь 14 ажилтантай, төрийн захиргааны төв байгууллагад 14, орон нутагт 31 жендэрийн мэргэжилтэнтэй ажиллаж байна.

Зураг 5. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо⁸⁰



80 <https://www.ncge.gov.mn/>

Жендэрийн үндэсний хороо жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.⁸¹

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах;
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцах, зөвлөгөө өгөх;
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхийг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаархи Засгийн газрын тайланг бэлтгэх ажлыг зохион байгуулах;
6. Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаархи Төрийн албаны зөвлөлийн тайлан, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаархи Монгол Улсын ээлжит тайлангийн төсөлтэй танилцах, санал өгөх;
7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлын талаархи тайлангийн төслийг хэлэлцэх, санал өгөх;
8. Жендэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн сүлжээ байгуулах, жендэрийн мэдээллийг хэрэглэгчид хүргэх ажлыг зохион байгуулах;
9. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалахад олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангах;
10. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх;
11. Жендэрийн салбар хороо, зөвлөлийн тайлан, мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт гаргах;
12. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлаар үр дүнд хүрсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг шагнал, урамшилд тодорхойлох;
13. Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, дүрмийг хэлэлцэж, батлуулах; жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах;
14. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлын талаархи тайланг бэлтгэж Засгийн газарт оруулах;
15. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг юм.

81 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, УБ.,2011, 18-р зүйл

ХОЁР

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

- 2.1 Хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн зохицуулалт
- 2.2 Хүн худалдаалах гэмт хэрэг ба эрүүгийн хууль
- 2.3 Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал
- 2.4 Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс
- 2.5 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ

2.1

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд уг гэмт хэргийг хар тамхи, мансууруулах бодис худалдах, тээвэрлэх зэрэг гэмт хэрэгтэй хавсран үйлдэж ихээхэн хэмжээний ашиг орлого олдог хууль бус бизнес болон өргөжиж байгаа нь дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудал хэвээр байсаар байгаа юм.

Манай улс үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг түүн дотроо хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хүчин чармайлт гаргаж, олон улсын өмнө гэрээ, конвенциор хүлээсэн үүргээ тодорхой хэмжээнд биелүүлж, хүчин чармайлт гаргаж буй тухай АНУ-ын Элчин сайдын яамнаас гаргадаг Хүн наймаалах асуудлын төлөв байдлын талаарх тайланд дурджээ⁸².

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалах чиглэлээр НҮБ болон түүний байгууллагуудаас батлан гаргасан 15 гэрээ, конвенциос 12-т нь Монгол Улс нэгдэн орсон⁸³.

Хүснэгт 5. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр батлагдсан Олон улсын гэрээ, конвенцийн жагсаалт

№	Гэрээ, конвенцийн нэр	Батлагдсан	Хүчин төгөлдөр болсон	Монгол Улс нэгдэн орсон
1.	Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29-р конвенц	1930.06.28	1932.05.01	2005.03.15
2.	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	1945.06.26	1945.10.24	1961.10.27
3.	Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц	1956.09.07	1957.04.30	1968.10.31
4.	Албадан хөдөлмөрийг устгах тухай ОУХБ-ын 105-р конвенц	1957.06.25	1959.01.17	2005.03.15
5.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1979.12.18	1981.09.03	1981.07.20
6.	Хүүхдийн эрхийн тухай конвенц	1989.11.20	1990.09.02	1990.01.26
7.	Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц	1993.05.29	1995.05.01	2000.04.25
8.	Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм	1998.07.18	2002.07.01	2002.04.05
9.	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182-р конвенц	1999.06.17	2000.11.19	2001.02.26
10.	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол	2000.05.25	2002.01.18	2001.11.12

82 <https://mn.usembassy.gov/mn/2021-trafficking-in-persons-report-mn/>

83 <http://mfa.gov.mn/#>

11.	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц	2000.11.15	2003.09.29	2008.05.16
12.	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол	2000.11.15	2003.12.25	2008.05.16

Гадаад харилцааны яамны мэдээллээр Монгол Улс 2020 оны байдлаар 300 орчим олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсон бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний протокол, Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт мэдээлэл хүргүүлэх журмын тухай III протоколын тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлж байна⁸⁴.

Монгол Улс 2002 онд баталсан Эрүүгийн хуульд анх удаа хүн хулгайлах, хүн худалдах, худалдан авах, хүний цус, эд эрхтэнг хууль бусаар авах гэмт хэргийг хуульчилсан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдэх эхлэл тавигдсан. Засгийн газраас 2005 онд “Хүн, ялангуяа эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, энэ чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зөв ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаанууд хийгдсэн байна. Улмаар 2008 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орсон.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4.2-т “хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгож энэ чиглэлд бэхжүүлнэ” гэж заасны дагуу 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хуулийг баталсан нь эрх зүйн орчныг бүрдүүлэх гол алхам болсон. Ингэснээр хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагуудын хүлээх үүргийг тодорхой болгож, хохирогчийг хамгаалах, тэдгээрт үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрүүдийг хуульчилсан.

Дээрх хууль болон Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль, Прокурорын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль зэрэг бусад хууль тогтоомж нь Монгол Улс эрүүгийн эрх зүйн орчныг шинэчлэх явцдаа хүний наймаатай тэмцэх чиглэлээр нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенцын агуулгатай нийцүүлэн уялдуулсан болохыг судалгааны тайлангуудад⁸⁵ дурдсан байна.

Өнөөдрийн байдлаар хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулах чиглэлд дараах гол хууль тогтоомжууд мөрдөгдөж байна.

84 <https://mfa.gov.mn/> болон <https://nhrcm.gov.mn/> цахим хуудаснаас дэлгэрүүлэн үзэх боломжтой.

85 ХЗДХЯ, Азийн сан, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдыг чадавхыг үнэлэх судалгааны тайлан, 2017

Хүснэгт 6. Хүн худалдаалахтай холбоотой үндэсний хууль тогтоомжууд

<p>Гол эрх зүйн баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - Эрүүгийн хууль - Зөрчлийн тухай хууль - Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль - Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 	<p>Бусад эрх зүйн баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Донорын тухай хууль - Зар сурталчилгааны тухай хууль - Засгийн газрын тусгай сангийн тухай хууль - Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль - Хөдөлмөрийн тухай хууль - Хүүхдийн эрхийн тухай хууль - Хүүхэд хамгааллын тухай хууль - Эрүүл мэндийн тухай хууль - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль - Боловсролын тухай хууль - Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль
<ul style="list-style-type: none"> - Шүүхийн тухай хууль - Прокурорын байгууллагын тухай хууль - Цагдаагийн албаны тухай хууль - Тагнуулын байгууллагын тухай хууль - Авлигын эсрэг хууль - Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль 	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал - Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр
<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Хилийн тухай хууль - Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль - Гаалийн тухай хууль - Улсын бүртгэлийн ерөнхий хууль - Төрийн хяналт шалгалтын тухай хууль 	

Тодруулбал, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалах талаар оролцогч талуудыг эрх хэмжээг тогтоосон эрх зүйн баримт бичиг нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль⁸⁶ юм.

Хүн худалдаалахтай тэмцэх нь бүх талуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр дүн байдаг тул хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талууд үүргээ хангалттай биелүүлэхийг нийгэм шаардсаар байдаг. Хүн худалдаалахтай тэмцэх хуульд зааснаар оролцогч талууд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

Хүснэгт 7. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогчдын бүрэн эрх

Оролцогч тал	Бүрэн эрх
Монгол Улсын Засгийн газар	<ul style="list-style-type: none"> - Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах; - Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах; - Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх.
Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	<ul style="list-style-type: none"> - Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан⁸⁷ бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулах; - Хүн худалдаалах асуудлаар мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах; - Улсын ерөнхий прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батлах.

86 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2012, №7

87 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1.төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлыг уялдуулан зохицуулах, Зохицуулах зөвлөлийг удирдах;

26.1.2.гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих, шалгах;

26.1.3.шүүх, прокурор, цагдаа болон хууль сахиулах бусад байгууллагатай зөвшилцөн улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;

26.1.4.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах;

26.1.5.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

26.1.6.гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах.

<p>Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан олон улсын гэрээнд нэгдэн орох санал боловсруулах, энэ талаар гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр хийх, нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах; - Гадаад улсад хохирогч болсон Монгол Улсын иргэний эрх ашгийг хамгаалах, түүнд туслалцаа үзүүлэх; - Энэ хуулийн 12.1.5-д заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих⁸⁸; - Гадаад улсын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын насанд хүрээгүй иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах.
<p>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Энэ хуулийн 12.1.3-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг⁸⁹ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих; - Хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх.
<p>Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг⁹⁰ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих; - Хохирогчид үйлчилгээ үзүүлэх асуудлаар эмнэлгийн байгууллагын ажилтанд сургалт явуулах.
<p>Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Боловсролын байгууллага, оюутан, сурагчдын дунд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах; - Хүн худалдаалахын хор уршиг, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тайлбарлан таниулах талаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөр, стандартад тусгах.
<p>Цагдаагийн болон тагнуулын байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Хүн худалдаалах үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, хүн худалдаалахтай холбоотой зар сурталчилгаанд хяналт тавина.
<p>Улсын хил хамгаалах байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа хүүхдийн биеийн байцаалтыг тодруулах, итгэмжлэлийн үндсэн дээр бусдын хүүхдийг харгалзан яваа этгээдийн биеийн байцаалт, ямар зорилгоор хүүхдийг дагуулан явж байгаа, тухайн хүүхэдтэй ямар холбоотой болох, хүлээн авагч гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шалгаж нягтлах; - Итгэмжлэлийн үндсэн дээр гадаад улсад зорчиж байгаа хүүхэд тухайн улсад удаан хугацаагаар сурах, амьдрах тохиолдолд хүлээн авах этгээдийн талаарх мэдээллийг нягтлах; - Улсын хилээр хамт гарсан насанд хүрээгүй хүнийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд эргэж ирээгүй шалтгааныг нь тодруулах, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх
<p>Мэргэжлийн хяналтын байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсадыг албадан хөдөлмөр, боолчлол, боолчлолтой ижил төстэй нөхцөлд ажиллуулж, байлгаж байгаа эсэхэд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавина.

88 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ
12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:

12.1.5.гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах.

89 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ
12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:

12.1.3.ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах;

90 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ
12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:


12.1.1.эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ;

12.1.2.сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ;

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих
Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	- Хүн худалдаалахад өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн улсын хэмжээнд цаашид авах арга хэмжээний санал боловсруулна
Бүх шатны нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага	- Нутаг дэвсгэртээ хүн худалдаалахтай тэмцэх, шалтгаан нөхцөлийг нь тогтоож арилгах арга хэмжээ авах; - Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; - Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах; - Хүн худалдаалахтай холбоотой байж болзошгүй зар сурталчилгаанд харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хяналт тавих.

Улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохион байгуулах чиг үүрэг бүхий зохицуулах зөвлөл ажиллах бөгөөд улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дагнан зохицуулах үүрэг бүхий Дэд зөвлөлийг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллуулж байна.

Зураг 6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөлүүд



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл ажиллана. Энэхүү дэд зөвлөл нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ⁹¹.

91 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2012, №7, 6-р зүйл

Зураг 7. Хүн худалдаалахтай тэмцэх дэд зөвлөлийн бүрэн эрх

Дэд зөвлөлийн хэрэгжүүлэх бүрэн эрх

1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тайлан мэдээллийг сонсох, шалгалт явуулах, зөвлөмж гаргах
2. Хүн худалдаалах нөхцөл байдлын талаар мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаа хийлгэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөр уламжлан Засгийн газарт оруулах;
3. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр бусад орны холбогдох байгууллагатай хамтран ажиллах чиглэл гаргаж хэрэгжүүлэх;
4. хүн худалдаалахтай тэмцэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, хамтран ажиллах, санал санаачилгыг нь дэмжих, олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;
5. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн, гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэх саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд гаргах, биелэлтийг шаардах;
6. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах арга хэмжээ авах;
7. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгуулах талаар санал боловсруулах;
8. Хүн худалдаалах, түүний хор уршгийн талаарх нэгдсэн мэдээг гаргах;
9. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;
10. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтныг мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.

2.2

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, энэ гэмт хэргийн улмаас хохирсон хүнийг таньж тогтоох, илрүүлэх, тэдэнд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах үндэс суурь нь энэ төрлийн гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголттой байх явдал юм.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гол бичиг баримт нь 2000 оны 11 дүгээр сарын 15-нд батлагдсан, манай улс 2008 оны 5 сарын 16-нд УИХ-аар соёрхон баталсныг 2008 оны 06 дугаар сарын 27-нд НҮБ-д бүртгэж авсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (цаашид Палермогийн протокол гэх) юм.⁹²

92 Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүний протокол

Уг протоколд:

- Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах үйлдлийг ойлгоно.
- Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.
- Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно гэжээ.

Протоколын уг тодорхойлолтын агуулгыг нарийвчлан задалбал ХХГХ-ийг тодорхойлоход үйлдэл, арга, зорилго гэсэн гурван бүрэлдэхүүн шинжийг авч үздэг.

Зураг 8. ХХГХ-ийн бүрэлдэхүүн шинж

Үйлдэл	Арга	Зорилго
<ul style="list-style-type: none"> - элсүүлэх - тээвэрлэх - дамжуулах - нуун далдлах - хүлээн авах 	<ul style="list-style-type: none"> - заналхийлэх, - хүч хэрэглэх - албадах - хулгайлах - хуурч мэхлэх - эмзэг байдлыг далимдуулах - төлбөр төлж хахуульдах 	<ul style="list-style-type: none"> - биеийг нь үнэлүүлэх - бэлгийн мөлжлөгт өртүүлэх - албадан хөдөлмөрлүүлэх - боолчлох, түүнтэй төстэй нөхцөлд байлгах - эд, эрхтнийг нь авах

ХХГХ-ийн зорилгын шинж тэмдгүүд нь тухайн хүнд юу тохиолдсон, яагаад тохиолдсон гэдэг дээр төвлөрдөг. Ялангуяа бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, албадан хөдөлмөр эсвэл үйлчилгээ үзүүлэх, хүчээр гэрлүүлэх зэргээр хүнийг мөлжиж, ашиг орлого олох сэдэл давамгайлдаг. Ихэнх хохирогчид мөлжлөгт өртсөнийхөө дараа хохирогчоор тогтоогддог бөгөөд мөлжлөг олон хэлбэрээр явагдаж байж болдог.

Монгол Улсад 2000 оны эхээр өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд боловсруулагдаж, батлагдсан 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд “Хүн худалдах, худалдан авах” гэмт хэргийг шинээр тусгасан (2008 онд Хүн худалдаалах гэж өөрчилсөн). Ийнхүү Эрүүгийн хуульд бие даасан зохицуулалт болж орсон хэдий ч хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг үйлдсэн этгээд хүнийг мөлжих зорилгоор худалдаалахдаа элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах гэсэн таван үе шатыг заавал дамжсан байхыг шаардсан нь энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдэж, шалгагдахгүй байх нөхцөлийг бий болгож байжээ.

Улмаар, Монгол Улс 2008 онд Палермогийн протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор тухайн үед мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж, 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд, Хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлахдаа уг протоколын тодорхойлолттой үндэсний тодорхойлолтыг зөрчилдөөнгүй болгосон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн нэг том алхам болжээ.

Хүснэгт 8. Палермо протокол, Эрүүгийн хуулийн харьцуулалт

Палермогийн протокол	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/
“Хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.	Хүн худалдаалах гэдэг нь “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.
ХХГХ-ийн шинжийн дагуу дээрх хоёр тодорхойлолтыг нарийвчлан задалбал:	
Зорилго Хүнийг мөлжих зорилгоор	Зорилго Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор
Үйлдлийн арга – хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, – хулгайлах, – залилах, – хууран мэхлэх, – эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, – эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах	Үйлдлийн арга – хүч хэрэглэх – хүч хэрэглэхээр заналхийлэх – хулгайлах – хууран мэхлэх – итгэл эвдэх – эрх мэдлээ урвуулах – эмзэг байдлыг нь далимдуулах – хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах
Үйлдэл хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах	Үйлдэл элсүүлэх; тээвэрлэх; орогнуулах; дамжуулах; хүлээн авах

Монгол Улсын Эрүүгийн хуульд ХХГХ-ийн талаар заасан зохицуулалт нь Палермогийн протоколын тодорхойлолттой агуулгын хувьд бүрэн нийцсэн болох нь харагдаж байна.

Хүснэгт 9. Хүн худалдаалах гэмт хэргийн зарим шинж, агуулгын тайлбар

Ойлголт, нэр томьёо	Тайлбар
Хүч хэрэглэсэн	Гэмт этгээд хохирогчийн бие махбодид халдаж, түүний эсэргүүцлийг няцаасан байхыг ойлгоно. Хохирогчийн бие махбодид халдах үйлдэл нь алгадах, цохих, түлхэх, дарах, хоолойг боох, зэрэг хэлбэртэй байж болно
Хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар үйлдсэн	Гэмт этгээд хохирогчийг болон ойр дотны хүнийг ална, эрүүл мэндэд хохирол учруулна, эрх, эрх чөлөөг хязгаарлана зэргээр айлан сүрдүүлсэн байхыг ойлгоно
Хулгайлсан	Хүнийг худалдаалах зорилгоор Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдэл хийхийг ойлгоно

Хууран мэхэлсэн	Үгээр буюу үйлдлээр бодит байдлыг нуун дарагдуулах эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлснийг ойлгоно. Тухайлбал хохирогчийг гадаад улсад өндөр цалинтай ажилд зуучилна, суралцуулна, тэтгэлэг олгуулна, виз гаргана зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ
Итгэл эвдсэн	Хоёр талын итгэлцэлд үндэслэх бөгөөд хохирогчид ашигтай нөхцөл бий болгоно гэж хуурамч гэрээ бичиг баримт ашиглан итгүүлэх, дараа нь итгэлийг нь хөсөрдүүлснийг ойлгоно
Эрх мэдлээ урвуулан ашигласан	Албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж үйлдсэнийг ойлгоно
Хохирогчийн эмзэг байдлыг далимдуулсан	Хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин түүнчлэн, амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно
Хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулсан	Хохирогчийг бүх хэлбэрээр хяналтдаа байлгаж буй этгээд өөртөө эдийн болон эдийн бус ашигтай байдлыг бий болгох болзолтойгоор бусдад хүнийг шилжүүлж буй үйлдлийг ойлгоно
Элсүүлсэн	Хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох, хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх үйлдлийг ойлгоно.
Тээвэрлэсэн	Хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй этгээдийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно
Дамжуулсан	Хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ
Орогнуулсан	Хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно
Хүлээн авсан	Худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно
Биеийг нь үнэлүүлэх	Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг түүнийг бусадтай төлбөртэйгэр бэлгийн харьцаанд оруулахыг ойлгоно
Бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах	Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг түүнийг садар самуун сурталчилсан кино, дүрс бичлэг, тайчих үзүүлбэр, тоглолт, уралдаан, тэмцээнд оруулахыг ойлгоно
Боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах	Хүн бусад хүнийг хүчээр өөрийн өмч болгон өөрийн дур хүсэл, сонирхлын дагуу ажиллуулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүнийг төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно
Эд эрхтнийг авах	Гэмт этгээд өөрийн болоод бусдын бие, эд, эрхтнийг нөхөн сэргээх, аль нэг эрхтнийг орлуулан солих, эсхүл бусдад худалдаалж ашиг олох зорилгоор хүний эд, эрхтнийг авсныг ойлгоно
Албадан хөдөлмөрлүүлэх	Хүний хүсэл зоригийн эсрэг илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, аливаа ажил үйлчилгээг цалин хөлсгүй гүйцэтгүүлэхийг ойлгоно

Хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж	Гэмт этгээд хохирогчийг 18 насанд хүрээгүй эсхүл жирэмсэн гэдгийг түүний гадаад төрх байдал, хоорондын харилцаа, эсхүл бусад эх сурвалжаас лавтай мэдэж байсныг ойлгоно
Хоёр, түүнээс олон хүнийг худалдаалсан	Гэмт этгээд хоёр буюу түүнээс олон хүнийг худалдаалах гэсэн нэгдмэл нэг санаа зорилгоо цаг хугацаанд, эсхүл тодорхой цаг хугацааны дараа хэрэгжүүлсэн байхыг хэлнэ
Монгол улсын хилээр нэвтрүүлсэн	Хүн худалдаалахын тулд Монгол улсын хилийг нууцаар эсхүл хуурамч буюу хууль ёсны баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийг ойлгоно
Хүн худалдаалах гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн	Энэ гэмт хэргийг гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байхыг ойлгоно
Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдэл үйлдсэнийг ойлгоно

Монгол Улс 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц болон түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд хүн ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх протоколд нэгдэн орсон. Энэ нь баримт бичиг нь ХХГХ-ийн гол объект болох эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг тусгайлан хамгаалсан чиг үүрэгтэй олон улсын эрх зүйн гол баримт бичиг болж байна. Уг протоколд насанд хүрээгүй хүний эсрэг энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд гэмт хэргийг ямар аргаар үйлдсэнийг хамаарахгүй гэдгийг онцолсон байдаг.



Хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхдийг худалдах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт үйлдлийг хуульчлахдаа гэмт хэргийн субъектив талын шинж болох гэмт хэргийн зорилгыг тодорхой заагаагүй ч эдгээр үйлдлийг хийлгэх нь гэмт хэрэг үйлдэгдэгчид тодорхой ашигтай байх нь тодорхой харагдаж байгаа юм. Мөн хүүхдэд садар самууныг сурталчлах, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан үйлдэл нь бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэрт хамаарна.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолд хүн худалдаалах гэмт хэргийн шинжүүдийг дараах байдлаар тайлбарласан. Үүнд:

- “Хүн худалдаалах” гэдэгт тодорхой төлбөртэйгөөр (мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно.
- “Ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг хэлнэ.
- “Бэлгийн хүчирхийлэлд оруулах” гэдэгт биеийг нь үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчлахад татаж оруулсан, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно гэжээ.

Мөн Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

Дээр дурдагдсан мэдээллийг сайтар уншиж судалснаар Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг агуулсан дараах гэмт хэргүүдээс ялгах чадвартай болох юм. Үүнд:

- 12.3 дүгээр зүйл. Бэлгийн мөлжлөг,

- 13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх,
- 15.3 дугаар зүйл. Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах,
- 16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах
- 16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах
- 16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах
- 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах
- 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг

2.3

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс нь далайд гарцгүй орон бөгөөд ОХУ, БНХАУ-тай ойролцоогоор 1,565 мянган хавтгай дөрвөлжин км² нутаг дэвсгэрээр хиллэдэг. Нийт хүн ам 3.2 сая бөгөөд тэдгээрийн 50.8% нь эмэгтэйчүүд. Хүн ам нь харьцангуй залуу буюу нийт хүн амын 30.4%-ийг 0-14 насныхан, 65.7%-ийг 15-64 насныхан эзэлдэг. Хүн амын дийлэнх хувийг халх (85%), дараа нь казахууд (7%) эзэлдэг ба үлдсэн хувь (8%)-ийг тува (цаатан), дархад, буриад зэрэг нийгэм, соёлын цөөнх бүлгүүд эзэлж байна.

Нийт хүн амын 66.4% нь хот суурин газар, уул уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт, харин 33.6% нь хөдөө орон нутагт амьдардаг. Уул уурхайгаас улбаалсан түүхий эдийн арвин нөөцтэйн улмаас 1999 оноос хойш 20 гаруй жилийн хугацаанд уул уурхайд түшиглэсэн эдийн засаг эрчимтэй өссөн. 2018 онд Монгол Улсын ядуурлын үндэсний түвшин 28.4% байсан нь 2016 оны тооцооллоос 1.2 пунктээр буурсан үзүүлэлт юм. Монгол Улс 2020 оны байдлаар Хүний хөгжлийн индексээр дэлхийн 189 орноос 99 дугаарт жагсаж байжээ.

Гэмт хэргийн гаралтын хувьд, 2020 оны байдлаар жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 100,000 хүн тутамд дунджаар 1080 гэмт хэрэг ноогдож байгаа нь хүн амын тоотой харьцуулахад гэмт хэргийн гаралт өндөр орны тоонд тооцогдож байна⁹³.

Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын хувьд Монгол Улс нь хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор үндэстэн дамнасан хүний наймааны гэмт хэргийн илгээгч, хүлээн авагч, дамжуулагч орны тоонд багтаж байна. Олон улсын болон дотоодод хийгдсэн олон судалгааны үр дүнгээр Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэг бэлгийн мөлжлөгийн хэлбэрээр зонхилон үйлдэгдэж байгаа талаар дурдсан байна. Тухайлбал, 10 жилийн өмнө хийгдсэн судалгаагаар хүн худалдаалах гэмт хэрэг нь дотооддоо 18-25 насны охид эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэх хэлбэр 70%, албадан хөдөлмөр буюу хүчээр хулгай, дээрэм хийлгэх, гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн газруудад ажиллуулах, гадаадад ажиллуулах нэрээр хөдөлмөрийг мөлжих хэлбэр нь 20 орчим хувь, зуучлалын захиалгат гэрлэлт (ихэвчлэн БНСУ, БНХАУ-ын иргэдтэй гэр бүл болдог) 10 хувь өртөж байна⁹⁴ гэжээ.

Хэдийгээр хүн худалдаалах гэмт хэргийн төрөл хэлбэрүүдийг хатуу ангилж, нарийн зааглахад төвөгтэй бөгөөд нэг хохирогч хүний наймааны хэд хэдэн хэлбэрт өртсөн байх боломжтой байдаг.


93 www.1212.mn статистикийн мэдээлэл

94 Б.Батзориг нарын бүтээл "МУ дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал" тайлан, 2010 он, 23 дахь тал

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар хийгдсэн олон судалгааны үр дүнд манай улсад бэлгийн мөлжлөг, хөдөлмөр мөлжлөг ба албадан хөдөлмөр, зуучлалын захиалгат гэрлэлт, хүүхэд худалдаалах гэсэн хэлбэрүүдээр үйлдэгдэж байна. Үүнээс бэлгийн мөлжлөгийн хэлбэр зонхилон үйлдэгдэж байгаа хэдий ч хөдөлмөр мөлжлөгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхгүй нөхцөл байдал хүндрэх хандлагатай гэж үзсэн нь ч байна⁹⁵.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд түүнээс хойш Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн статистикийн мэдээллийг авч үзвэл сүүлийн 2 жилийн хугацаанд харьцангуй буурах үзүүлэлттэй харагдаж байгаа боловч энэ нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдлын улмаас улс орон даяар хөдөлгөөний хязгаарлалт тогтоож, улс хооронд зорчих хөдөлгөөн хаагдсантай холбон тайлбарлаж болох талтай.

Зураг 9. Хүн худалдаалах гэмт хэргийн статистик



Манай улсад сүүлийн 5 жилд шүүхээр шийдвэрлэсэн хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийн шийдвэрлэлтийг тусад нь авч үзвэл хүн худалдаалах гэмт хэрэг 4, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг 2, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 3, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг 6, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг 2 тус тус эцэслэн шийдвэрлэгдсэн байна⁹⁶.

Зураг 10. Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн шийдвэрлэлтийн зураглал



Тодруулбал, 2017-2021 онд цагдаагийн байгууллагад хүн худалдаалах, түүнтэй төстэй⁹⁷ гэмт хэрэг нийт 241 бүртгэгдэж, 3 хэрэг хэрэгсэхгүй болж, 137 хэргийн хэрэг бүртгэлтийг хаасан нь

⁹⁵ Мөн тэнд
⁹⁶ Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагаас авсан мэдээ
⁹⁷ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дүгээр зүйл. Бэлгийн мөлжлөг, 13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 дугаар зүйл. Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах, 16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг

нийт гэмт хэргийн 58% нь мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын шатанд дуусгавар болж байгаа нь харагдаж байна. Харин шүүхэд 53 хэргийг шилжүүлснээс 17 хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэдэг байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоон үзүүлэлтийн хооронд гарч буй зөрүү нь дараах шалтгаантай байна⁹⁸. Үүнд:

- цагдаа, тагнуулын байгууллагад анх бүртгэгдэхдээ яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй эсхүл хаана байгаа газар нь мэдэгдэхгүй байх,
- энэ төрлийн гэмт хэргийг нэг биш хэд хэдэн хүн хамтран үйлддэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрийг олж тогтооход ажиллагаа шаарддаг,
- энэ гэмт хэрэгт өртөж хохирсон хүмүүс оршин суух газраа орхиж явах, гэр бүлтэй болоод өөрсдөө зайлсхийх, шүүгдэгчтэй таарах нөхцөл байдлаас зугтаах зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй байх,
- хил дамнаж үйлдэгдсэн хэрэгт зайлшгүй шаардлагаар тухайн гадаад улсад нотлох баримт цуглуулах ажиллагаа явуулах,
- шүүхэд шилжсэн хэрэгт шүүгдэгч, тэдгээрийн өмгөөлөгчдийн зүгээс шүүх хуралдааныг хойшлуулах бүх үндэслэлийг ашиглах гэх мэт.

Палермогийн протокол, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Эрүүгийн хуульд заасан энэ төрлийн гэмт хэргийн тодорхойлолтоос дараах хэлбэртэй болохыг харж болох юм.

Зураг 11. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, хэлбэр



Эдгээр хэлбэрүүдээс бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх нь манай улсад түгээмэл ажиглагддаг.

1. Бэлгийн мөлжлөг

Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн 12.3 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан” үйлдлийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг гэж хуульчилсан. Мөн хуулийн 13.1-р зүйл буюу Хүн худалдаалах гэмт хэргээс ялгагдах нэг шинж нь “зорчих эрхийг хязгаарласан эсэх” юм.

Бэлгийн мөлжлөг нь зарим тохиолдолд гэмт этгээд хохирогчдод тэднийг тээвэрлэн авчрах үед гарсан зардал, тэднийг ажиллуулахад зарцуулсан зардал, түүнчлэн тэднийг амьдрахад зарцуулж буй зардлаа хүүгийн хамт төлөхийг шаардах зэргээр хууль бусаар өрөнд оруулж, энэхүү өрөө төлсөн тохиолдолд өөрсдийг нь чөлөөтэй явуулна хэмээн амлах, хүч хэрэглэн биеийг нь үнэлэх явдлаар үйлдэгддэг. Түүнчлэн хохирогч хэдийгээр анхнаасаа биеэ үнэлэх зорилготой байсан боловч ийнхүү биеэ үнэлэхээр зөвшөөрснийх нь дараа тэднийг сэтгэл зүйн хувьд дарамтлах, биед нь хүч хэрэглэх замаар биеийг нь үнэлүүлэх тохиолдлууд олон бөгөөд эдгээр тохиолдлыг мөн адил хүний наймааны хохирогч гэж авч үзэж байна.

⁹⁸ Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, Судалгааны тайлан, УБ.,2022

НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс 2022 онд хийсэн “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа” судалгааны тайланд дурдсанаар бэлгийн мөлжлөгийн хохирогчийн дүр төрхийг дараах хэлбэрээр гаргасан байна⁹⁹. Үүнд:

Зураг 12. Бэлгийн мөлжлөгийн хохирогчдын ерөнхий профайл


	ДОТООД (N=93)	ГАДААД (N=38)
Хохирогчийн ерөнхий мэдээлэл	<ul style="list-style-type: none"> Хүйс: Эмэгтэй Дундаж нас: 15-22 нас Боловсрол: Бага болон бүрэн дунд Мөлжлөгт өртүүлсэн дундаж хугацаа: 3 сар 	<ul style="list-style-type: none"> Хүйс: Эмэгтэй Дундаж нас: 19-24 нас Боловсрол: Бага болон бүрэн дунд Мөлжлөгт өртүүлсэн дундаж хугацаа: 3 сар
Хэрэг үйлдэгдсэн анхдагч байршил	Монгол Улс, Улаанбаатар хот Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй зэрэг дүүргүүд	Монгол Улс, Улаанбаатар хот
Бэлгийн мөлжлөгт өртүүлсэн байршил	Монгол Улс, Улаанбаатар хот Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй зэрэг дүүргүүд	<ul style="list-style-type: none"> БНХАУ Хонг Конг, Макао, Сингапур, Малайз, Камбожи, Мьянмар, БНСУ, Филиппин
Хохирогчийг элсүүлсэн арга	<ul style="list-style-type: none"> Эмзэг байдлыг далимдуулах Өрийн барьцаа Залилан хуурах Архи, хар тамхи хэрэглүүлэх Итгэлийг нь олж авах Заналхийлэх Хүч хэрэглэх 	<ul style="list-style-type: none"> Залилан хуурах Өрийн барьцаа Эмзэг байдлыг далимдуулах Заналхийлэх Итгэлийг олж авах Архи, хар тамхи хэрэглүүлэх
Бэлгийн мөлжлөгт өртүүлж буй чиг хандлага	<ul style="list-style-type: none"> Цахим орчинд санхүү өгнө авна гэсэн албан бус зараар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх болсон. Фейсбүүкийн чат, видео дуудлага хэлбэр түлхүү ашиглагдан ХХГХ-т өртүүлэх, хохирогчийг элсүүлэх ажил хийгдэж байна. Цар тахалтай холбоотойгоор гудамж талбай, караоке, саун зэрэг газрууд хаагдаж далд хэлбэр лүү шилжсэн. 	<ul style="list-style-type: none"> Эхний хохирогч нь суллагдахын тулд дараагийн хохирогчийг өөрний таньдаг хүрээллээсээ олж, хуурч мэхлэн аврах байдлаар элсүүлдэг. Ихэвчлэн өрийн дарамттад орсон найз, нөхөд рүүгээ холбогдон цалин сайт ажил хийж байгаа байдлаа видео хэлбэрээр тогтмол илгээдэг. Мөн тогтмол видео ярилцлага хийдэг. Хурдан шийдвэр гаргахыг ятгадаг. Өөрөө богино хугацаанд их мөнгө олсон одоо буцахаасаа өмнө чамайг ажилд оруулаад өгөө гэх зэргээр сайн сэтгэл гаргаж буй мэт өөртөө дасган, найзынхаа итгэлийг нь олж авдаг. Бүх зардлыг нь даана. Ирээд төлөх боломжтой гэдэг. Билетыг хүртэл цахимаар захиалан ирүүлдэг байна. Эцсийн зогсоол хүртэл тухайн хүнээс ямар нэгэн төлбөр мөнгө гаргадаггүй.

99 НҮБ-ын ОУШХБ-ын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, УБ.,2021 <https://mongolia.iom.int/resources/baseline-assessment-causes-dynamics-vulnerability-and-resilience-levels-human-trafficking-mongolia>

Хохирогчдын профайлаас үзвэл энэ төрлийн гэмт хэрэгт дотооддоо өртөж буй охид, эмэгтэйчүүд насны хувьд 15-22 настай байхад гадаадад энэ төрлийн гэмт хэрэгт өртөж байгаа эмэгтэйчүүдийн насны хувьд 19-24 нас байгаагаас харвал дотоод дахь бэлгийн мөлжлөгийн хохирогч нь насанд хүрээгүй хүн байх нь илүү давамгайл байна.

Цагдаагийн байгууллагад 2017-2021 онд бүртгэгдсэн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тоон статистикийг авч үзвэл:

Зураг 13. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн статистик



Бэлгийн мөлжлөгийн хохирогч байж болзошгүй хүний профайлыг зураг 12-т үзүүлсэн. Иймд тодорхой нутаг дэвсгэр хариуцан иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагч, мэргэжилтнүүд энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирч болзошгүй хүмүүсийг таних, илрүүлэх, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой байна.

2. Албадан хөдөлмөрлүүлж мөлжих

Хохирогчид учирч болзошгүй аюул заналхийлэл нь бие махбод, сэтгэл санаа, санхүү болон бусад хэлбэрээр илэрч болох бөгөөд хэт бага цалин хөлс олгох эсвэл огт олгохгүй байх, хөдөлгөөн, харилцаа холбоог хязгаарлах, бие махбодын хүчирхийлэл хэрэглэх, хувь хүний эрх, боломжийг хясан боогдуулах, ажлын муу нөхцөлд шилжүүлэх болон хууль бус цагаачлагчдыг холбогдох хууль хяналтын байгууллагуудад мэдээлэх зэрэг олон арга хэлбэрээр илэрдэг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (цаашид ОУХБ гэх)-аас эмзэг байдлыг буруугаар ашиглах, хууран мэхлэх, чөлөөтэй зорчихыг хязгаарлах, хорих, тусгаарлах, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл, айлган сүрдүүлэх, заналхийлэх, бичиг баримт барьцаалах, цалин хөлс олгохгүй байх, өрийн барьцаа, төлөөс болгох, ажиллаж, амьдрахад хортой хүнд нөхцөлд, илүү цагаар ажиллуулах зэрэг нь албадан хөдөлмөр мөн эсэхийг тогтоох шалгуур болно гэж үзжээ.

Тухайн нөхцөл байдалд эдгээр шинж тэмдгийн аль нэг нь эсвэл хэд хэдэн шинж тэмдэг нэгэн зэрэг илэрвэл албадан хөдөлмөр гэж тодорхойлж болно. Тиймээс энэ нь хэн нэгэн уг гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг үнэлж дүгнэх үндэс болж байна.

Манай улсын хувьд 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд анх удаа албадан хөдөлмөрлүүлэх гэсэн гэмт хэргийг хүн худалдаалах гэмт хэргээс гадна бие даалган хуульчилж өгсөн.

НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс 2022 онд хийсэн “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа”-ны тайланд дурдсанаар албадан хөдөлмөрийн хохирогчийн дүр төрхийг дараах хэлбэрээр гаргасан байна¹⁰⁰.

100 НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, УБ.,2021 <https://mongolia.iom.int/resources/baseline-assessment-causes-dynamics-vulnerability-and-resilience-levels-human-trafficking-mongolia>


Зураг 14. Албадан хөдөлмөрийн хохирогчийн профайл

	ДОТООД	ГАДААД
Хохирогчийн ерөнхий мэдээлэл	<ul style="list-style-type: none"> Хүйс: Эрэгтэй, эмэгтэй Дундаж нас: 14-40 нас Боловсрол: Бага болон бүрэн дунд Мөлжлөгийн үргэлжилсэн хугацаа: 6 сараас 2 жил хүртэл 	<ul style="list-style-type: none"> Хүйс: Эрэгтэй, эмэгтэй Дундаж нас: 18-40 нас Боловсрол: Бага болон бүрэн дунд Мөлжлөгийн үргэлжилсэн хугацаа: 6 сараас 2 жил хүртэл
Хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлсэн байршил	Монгол Улс, Улаанбаатар хот	<ul style="list-style-type: none"> БНХАУ, Манжуур хот Бүгд Найрамдах Турк Улс, Анкара хот Бүгд Найрамдах Солонгос Улс Бүгд Найрамдах Энэтхэг Улс Сингапур Улс, Тайкашимага гудамж Египет Улс, Александра хот Казахстан, Норвеги, Швед, Сингапур
Хохирогчийг элсүүлсэн арга	<ul style="list-style-type: none"> Эмзэг байдлыг далимдуулах Заналхийлэх Хүч хэрэглэх 	<ul style="list-style-type: none"> Залилах хуурах Эмзэг байдлыг далимдуулах Өрийн барьцаа Заналхийлэх Хүч хэрэглэх
Эрхлүүлж буй хөдөлмөр	Массажист	<ul style="list-style-type: none"> Мал маллах Гуйлга гуйлгах Гэрийн үйлчлэгчээр ажиллуулах Оёдлын үйлвэрт ажиллуулах Циркийн болон урлагийн тоглолт хийлгэх

Хохирогч иргэдийн ерөнхий мэдээллийг үзвэл уг гэмт хэрэгт эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн хүмүүс өртдөг. Хохирогчдын ажиллаж буй нийтлэг салбарын хувьд Монгол Улсын иргэд гадаад улс оронд хөдөө аж ахуй, үйлдвэр, урлагийн салбаруудад хөдөлмөр мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байна. Үүнээс гадна Монгол Улсад барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхайн салбарт гэрээгээр ажиллаж буй гадаад улсын иргэд ХХГХ-т өртөх эрсдэл өндөр байна. Тухайлбал, өнгөрсөн 2020 онд хөдөлмөр зуучлалын байгууллагаар зуучлуулан Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн гурван Мьянмар эмэгтэй хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болсон тохиолдол бүртгэгдсэн байдаг ч шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Цагдаагийн байгууллагад сүүлийн 5 жилд хүн худалдаалах гэмт хэргийн хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн тохиолдол бүртгэгдээгүй. Харин Эрүүгийн хуулийн 13.10 дугаар зүйлд заасан Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг 5 бүртгэгдсэн ч бүгд хэрэгсэхгүй болж шийдвэрлэгдсэн байна.

Зураг 15. Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн статистик



Гэтэл Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ын мэдээгээр 2003-2018 оны хооронд туслалцаа авсан нийт хохирогчийн ойролцоогоор 22% нь хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болсон иргэд байна гэсэн судалгаа гарсан байдаг нь анхаарал татах зүйл юм. Өөрөөр хэлбэл үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандсан болон хуулийн байгууллагад мэдэгдсэн тохиолдлыг харвал албадан хөдөлмөрлүүлэх хэргийн илрүүлэлт хангалтгүй явагдаж байгаа нь харагдаж байна.

Үүний шалтгааныг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнд зөвхөн цалин хөлсгүйгээр хөдөлмөрлүүлсэн л бол албадан хөдөлмөрлүүлэх гэж тооцохоор, харин цалин хөлс олгосон бол албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг гэж үзэхгүй байхаар хуульд тусгасан нь нөлөөтэй байх талтайг Монголын Хуульчдын Холбооноос хийсэн нэгэн судалгааны тайланд дурджээ. Түүнээс гадна албадан хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгийн талаар талуудын ойлголт, мэдлэг тааруу байгаа нь хохирогчийг илрүүлэх ажиллагаа сул явагдахад нөлөөлж буй нэг хүчин зүйл болдог.

Эдгээр мэдээлэлд үндэслэвэл ХХГХ-т өртсөн эрэгтэй хохирогчдын тоо улам нэмэгдэж буй нь зөвхөн эмэгтэйчүүд ХХГХ-т өртдөг гэх ойлголтыг няцааж байна. ХТЭТ-өөр 2003-2018 оны хооронд үйлчлүүлсэн нийт хохирогчдын 13 хувь нь эрэгтэйчүүд байсан. Уг судалгааны үр дүнгээр мөн хүйсийн ялгаатай байдал нь ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөгүйг харуулсан дээрх олон эх сурвалжийн үр дүнгүүд нь нэг ижил дүгнэлтэд хүргэж байна.

Хэдийгээр ХХГХ-ийн хохирогчид нь нийтлэг охид, эмэгтэйчүүд байгаа хэвээр боловч эрэгтэйчүүдийн энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байгаа нь эрэгтэй хохирогчдыг илрүүлэх, эрэгтэйчүүд рүү урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай байна.

3. Зуучлалын захиалгат гэрлэлт

Монгол Улсад иргэдийг гэр бүл болоход зуучлах асуудлыг зохицуулсан хуулийн заалт одоогоор байхгүй. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд ч гэр бүл зуучлалын үйлчилгээ явуулах эрхийг ямар нэгэн байгууллагад олгохоор заагаагүй буюу хуулиар энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөөгүй.

Гэвч 2003-2020 оны хооронд өндөр хөгжилтэй улс орнуудад, ялангуяа БНСУ руу Монгол охид, эмэгтэйчүүдийг тодорхой төлбөртэйгөөр гэрлүүлэх, гэр бүл зуучлалын үйл ажиллагааг хувь хүн, компани зохион байгуулдаг байсан талаар мэдээлэл байна. Тодруулбал, 2005-2012 оны хооронд ХТЭТ-д (45 хүн), Хүний эрх, хөгжил төвд (2 хүн) гадаад хүнтэй гэр бүл болохоор зуучлуулаад ХХГХ-ийн хохирогч болсон иргэд хандаж, туслалцаа авч байжээ.

Тэдний олонх нь харийн нутагт очиж, хүчирхийлэл дарамтад өртөж, байнгын боолчлолын нөхцөлд ажил хөдөлмөр эрхлэх, зарцлагдах, ажлын хязгааргүй цагаар, цалин хөлсгүй ажиллах, биеийг нь үнэлүүлэх зэрэг хүнд нөхцөлд орсон хохирогчид байсан байна. Гэвч эдгээр хэргүүдийн аль нь ч ХХГХ-ээр хуулийн байгууллагаар шийдвэрлэгдээгүй байна. Гэвч эдгээр хохирогчтой холбоотой ХХГХ-ээр эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгагдсан талаар мэдээлэл байсангүй. Мөн цагдаагийн байгууллагад 2018-2020 онд ХХГХ-т зуучлалын захиалгат гэрлэлттэй холбоотойгоор бүртгэгдсэн хэрэг байхгүй.

Зуучлалаар гэрлэх, гэрлээд хууртагдсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх тухай тусгайлсан заалт Эрүүгийн хуульд байхгүй хэдий ч хэрвээ энэ төрлийн хэрэг хууль хяналтын байгууллагад бүртгэгдсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн 13.1-р зүйл заалтын агуулга нь тус гэмт хэргийн шинжийг бүрэн агуулсан байна. Тодруулбал, 13.1-р зүйлд хүч хэрэглэх, хэрэглэхээр заналхийлэх,

хууран мэхлэх, итгэлийг нь эвдэх аргаар мөлжих, боолчлох болон түүнтэй адилтгах зорилгоор бусдыг элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх зэрэг үйлдлүүдийг хийсэн бол ХХГХ-т тооцохоор заасан. Иймд мөлжих, эсвэл худалдаалах санаа зорилгоор охид, эмэгтэйчүүдийг гэрлүүлсэн, гэрлэхэд нь зуучилсан бол Эрүүгийн хуулийн 13.1-д заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлтэй юм.

4. Хүүхэд худалдах

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 16.6 дугаар зүйл буюу Хүүхэд худалдах гэдэгт төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан нь тус хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол 10,000-40,000 нэгж¹⁰¹-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 2-8 жил хүртэл хугацаагаар хорих эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Харин Эрүүгийн хуулийн 13.1-д заасан “хүн худалдаалах” гэмт хэргээр сүүлийн гурван жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэгт 131 хохирогч тогтоогдсоны 35 хувь нь насанд хүрээгүй хүн буюу 14-18 хүртэлх насны хохирогч байна. Эндээс үзэхэд ХХГХ-т өртсөн насанд хүрээгүй хохирогчдын асуудлыг Эрүүгийн хуулийн 13.1-р зүйл ангиар нийтлэг шийдвэрлэж байна.

Манай улсад хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн маш болон зөрчлүүд байдаг. Тухайлбал, хүүхдийг албан бус секторт хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, хурдан морь унуулах, уран нугараачаар ажиллуулах, гэрийн үйлчлэгч хийлгэх, мал маллуулах, гуйлга гуйлгах зэрэг нь хөдөлмөр мөлжлөгийн хэргүүд бөгөөд хэзээ ч шийдвэрлэгдэж байгаагүй байна.

5. Эд эрхтнийг авах

Хэдийгээр манай улсад хүний цус, эд, эрхтнийг хууль бусаар авсан тохиолдол хуулийн байгууллагад болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ч бүртгэгдээгүй хэдий ч эрхтэн шилжүүлэн суулгах шаардлагатай өвчтөнүүдийн жагсаалт энэ төрлийн хагалгаа хөгжсөн улс орнуудад эрчимтэй нэмэгдэж байгааг харгалзвал тус хэргийн онцлог, маш нуугдмал далд аргаар, хууль ёсны мэтээр харагдуулж, үйлдэж байхыг үгүйсгэхгүй юм.

Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн салбарт бэлэн донор эрхтний нийлүүлэлт үргэлж хомсдолтой, харин эрэлт нь байнга нэмэгдэж байгаагаас болж эд эрхтний наймаа үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болох эрсдэлтэй.

Монгол Улсын Их Хурлаас 2018 онд Донорын тухай хуулийг шинэчилэн найруулж баталсан ба энэ хууль хэрэгжсэнээр донор болох зөвшөөрлийг нас барахын өмнө өөрөөс нь, нас барсны дараа гэр бүлийн гишүүн, төрсөн эцэг, эх, харгалзан дэмжигчээс нь тус тус авах, донорын эгнээг өргөжүүлэх, донорын зар сурталчилгаа болон зуучлалыг хориглож, хүний цус, эд, эрхтний наймаанаас сэргийлэх нөхцөл бүрдсэн.

Шилжүүлэн суулгах эс, эд, эрхтнийг амьгүй донороос авах бөгөөд хэрэв амьд донороос авах бол эс, эдийн тохироо нь нийцсэн, эмгэг өөрчлөлтгүй, гэр бүлийн гишүүнээс авахаар хуульчилсан нь хүний цус, эс, эд эрхтнийг хууль бусаар худалдаалах явдлаас урьдчилан сэргийлэх баталгаа юм. Мөн хүүхдээс ясны хэм, үүдэл эс, чөмөг, хүйн цуснаас бусад эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглосон нь хүүхдийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах онцлог зохицуулалт байдаг.

101 Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалт “нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна”

Мөн хуульд “эрүүл мэндийн шалтгаанаар өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон эмэгтэйд тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрнө” хэмээсэн нь тээгч эхтэй холбоотой хүүхэд худалдаалах явдлаас урьдчилан сэргийлэх бас нэг заалт болжээ.

2.3.1. Хүн худалдаалах гэмт хэргийн урсгал

Хүн худалдаалах гэмт хэргийг ихэнхдээ гадаад улсад буюу хохирогчийг хил давуулан бусдад худалдаж ашиг олох зорилгоор үйлддэг гэж олонх нь боддог ч энэ төрлийн гэмт хэрэг нь дотоодод ч мөн үйлдэгдэж байгааг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн шийтгэх тогтоол, магадлалаас харж болохоор байна¹⁰².

Дотоодод үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэг нь ядуурал ихтэй, хөдөлмөр эрхлэлт багатай, гэр бүлийн хүчирхийлэл ихтэй орон нутгийн иргэд боломжийн цалин хөлсний төлөө хөдөлмөрийн аюултай сонголт хийх замаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл өндөр байдаг¹⁰³.

Өөрөөр хэлбэл хүн худалдаалах гэмт хэрэг орон нутагт үйлдэгдэх магадлалыг дараах суурь хүчин зүйлс нэмэгдүүлдэг гэж үздэг байна. Үүнд:

- Ядуурал буюу амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх ихтэй
- Гэмт хэргийн гаралт өндөр
- Гэр бүлийн хүчирхийллийн гаралт өндөр
- Шилжилт хөдөлгөөн ихтэй
- Хөдөлмөр эрхлэлт бага
- Сургуульд хамрагдалтын түвшин бага

Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн шийтгэх тогтоол, магадлалд шинжилгээ хийж үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг нийслэлд хамгийн их бүртгэгддэг байна. Харин уул уурхай, газар тариалан, мал аж ахуй болон хөрш улсуудтай ялангуяа БНХАУ-тай хиллэдэг бүс нутгуудад энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх магадлал өндөр байдаг¹⁰⁴.

Улс дотроо үйлдэгдэж буй хүний наймааны хэлбэрүүдийг харвал эрэлт хэрэгцээг үүсгэж байгаа буюу бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр, биеэ үнэлэлтийг өөгшүүлж буй гол хэрэглэгч талууд нь Монголчууд өөрсдөө байхаас гадна гадны иргэд насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох сонирхлоор Монголд жуулчилдаг талаар бусад судалгааны тайлангуудад дурджээ. Мөн Япон, БНСУ-ын жуулчид насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох сонирхлоор Монголд ирдэг ба энэ нь сүүлийн жилүүдэд улам даамжирч байж болзошгүй талаар тэмдэглэсэн байна¹⁰⁵.

Мөн Монголын хүний эрхийн форумоос НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл¹⁰⁶-д илгээсэн тайланд сүүлийн үед Хятад компаниуд монгол хөвгүүд, эрчүүдийг хөдөө аж ахуйн чиглэлээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэт доогуур цалин өгч ажиллуулах зэргээр хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлж байгааг дурджээ.

102 www.new.shuukh.mn хуудаснаас хайлт хийх

103 НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, УБ.,2021 <https://mongolia.iom.int/resources/baseline-assessment-causes-dynamics-vulnerability-and-resilience-levels-human-trafficking-mongolia>

104 НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, УБ.,2021 <https://mongolia.iom.int/resources/baseline-assessment-causes-dynamics-vulnerability-and-resilience-levels-human-trafficking-mongolia>

105 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан, АНУ-ын төрийн департамент

106 www.upr-mongol.mn

Монголчуудыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгож, хилийн чанадад бусдад худалдаж, ашиг олох явдал байсаар байгаа бөгөөд олон улсын байгууллага, дотоодын судалгааны байгууллагуудын мэдээллээр монгол хүнийг хил дамжуулан худалдаалан тээвэрлэдэг газруудад ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, Малайз, Израил, Турк, Швейцар, Унгар, хуучин Югослав зэрэг орнуудыг нэрлэсэн байна.¹⁰⁷

Мөн АНУ-ын Хүний наймаалах асуудлын төлөв байдлын тухай 2021 оны тайлан илтгэлд Насанд хүрсэн болон хүрээгүй хүмүүсийг албадан хөдөлмөр эрхлүүлэхээр Хятад, Энэтхэг, Казакстан, Норвеги, Швед, Турк болон Арабын Нэгдсэн Эмират улсуудад, харин бэлгийн мөлжлөгт ашиглахаар Бельги, Камбож, Хятад, Герман, Хонконг, Япон, Макао, Малайз, Филлипин, Өмнөд Солонгос, Швед, Турк, АНУ руу болон Монголд дотооддоо худалдаж байна гэжээ.

ХТЭТ ТББ нь гадаад улсад хүний наймааны хохирогч болсон иргэдийг эх оронд нь эгүүлэн авчрах үйл ажиллагааг төрийн байгууллагатай хамтран зохион байгуулдаг гол байгууллагын нэг. Тус байгууллагын мэдээгээр сүүлийн 6 жилийн хугацаанд БНХАУ, Казакстан, Турк, Малайз, Филиппин, Макао, Камбож, БНСУ, Украин, Хонгконг гэсэн 10 улсаас 293 хохирогчийг эгүүлэн авчирсан байна¹⁰⁸.

Харин ЦЕГ болон ГХЯ-ны мэдээллээр хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийг доорх хүснэгтэд багтсан гадаадын улсуудаас авчирчээ.

Хүснэгт 10. Гадаад улсад ХХГХ-т өртөж хохирсон иргэдийг эх оронд нь эгүүлэн авчирсан тоон үзүүлэлт

2018	2019	2020
БНХАУ - 28 АНУ - 1 Малайз - 2 Мьянмар - 3 Камбож - 4	Камбожи улс - 4 БНКир Улс - 1 Филиппин улс -1 БНХАУ - 17 Сингапур - 4 Турк - 1	Малайз улс 28

Иймээс гадаад улсад зорчихоор явж буй иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлгийг тогтмол түгээж байх нь энэ төрлийн гэмт хэрэгт иргэдийг өртөж хохирохоос хамгаалах чухал алхам болох юм.

107 Азийн сан “Монголын уурхайн газар дах биеэ үнэлэлт ба хүний наймаа” судалгаа, Улаанбаатар хот, 2008 он

108 НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, УБ.,2021 <https://mongolia.iom.int/resources/baseline-assessment-causes-dynamics-vulnerability-and-resilience-levels-human-trafficking-mongolia>

Зураг 16. ХТЭТ ТББ-аас хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан чиглэлээр хилийн шалган нэвтрүүлэх цэгүүдэд байршуулдаг зурагт хуудас

**ХААНААС ЗӨВЛӨГӨӨ ТУСЛАМЖ АВАХ,
ХАМТРАН АЖИЛЛАХ ВЭ?**

БНХАУ Бээжин дэх ЭСЯ
Утас: 86 (10) 6532 1203, 86 (10) 6532 6512
Цахим хаяг: beijing@mfa.gov.mn, www.beijing.embassy.mn

Эрэн дахь Консулын газар
Утас: 976 92269000, 86 (479) 7589201
Цахим хаяг: ereen@mfa.gov.mn, www.ereen.consul.mn

ОХУ Москва дахь ЭСЯ
Утас: 7 (499) 252-78-67, 7 (495) 691-46-36
Цахим хаяг: moscow@mfa.gov.mn, mongolconsul@gmail.com

Истанбул дахь Ерөнхий Консулын газар
Утас: 90 (212) 662 6162 141
Цахим хаяг: istanbul@mfa.gov.mn, www.istanbul.consul.mn

БНСУ-д суугаа ЭСЯ
Утас: 82 (2) 798 3464, 82 (2) 795 1950, 82 (2) 794 7605
Цахим хаяг: seoul@mfa.gov.mn, www.mongolembassy.com, www.fb.com/embassyofmongolia

Сингапур Улсад суугаа ЭСЯ
Утас: 65 6348 0745, 65 6348 1753
Цахим хаяг: singapore@mfa.gov.mn, www.mongolianembassy.sg

Тайландын Хаант Улсад суугаа ЭСЯ
Утас: 66 (2) 381 1400, 66 (02) 392 1011, 66 (2) 392 4199
Цахим хаяг: bangkok@mfa.gov.mn

Хонконг дахь Ерөнхий Консулын газар
Утас: 852 25222400, 852 25222405
Цахим хаяг: hongkong@mfa.gov.mn, www.hongkong.consul.mn

БНЧУ-д суугаа ЭСЯ
Утас: 420 (2) 24311198, 420 (2) 24314827
Цахим хаяг: prague@mfa.gov.mn, www.prague.embassy.mn

ЦЕГ-н Эрүүгийн Цагдаагийн Алба
Утас: 7019-1420, 262425
Цахим хаяг: info@police.gov.mn, criminalpolice395@gmail.com

Таны өгсөн мэдээллийн нууцыг бид чандлан хадгална.




АНХААР

Энэхүү мэдээллийг **ТА** өөрөө мэдэж, бусдад сэрэмжлүүлсэнээр гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадна.



ИТГЭЛИЙН УТАС

1800-1903

Энгийн утасны тарифтай



ХҮЙСҮЙН ТЭГШ ЭХХ ТӨВ

2.4

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй суурь шалтгаан нь маш өргөн хүрээний асуудлаас эхтэй бөгөөд харилцан уялдаатай, давхардсан олон шалтгаануудын харилцан нөлөөллөөр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бүрддэг. Хэдийгээр улс орны онцлогоос шалтгаалаад гэмт үйлдлийн шалтгаан ялгаатай байх хэдий ч хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шалтгаан нь дэлхий даяар ижил байсаар байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн суурь шалтгаан нь улс орнуудын нийгэм, соёл, улс төрийн харилцан нөлөөн дор дараах суурь шалтгаанууд түгээмэл тохиолдож байгааг НҮБ-ын Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх газар¹⁰⁹, Австрийн Хүний Эрхийн Карьер (HRC)¹¹⁰ болон АНУ-ын

109 https://www.unodc.org/documents/human-trafficking/Toolkit-files/08-58296_tool_9-2.pdf

110 <https://www.humanrightscareers.com/issues/10-causes-of-human-trafficking/>

Хүний наймааны судалгааны хүрээлэн¹¹¹-гийн тайлангуудад дурджээ. Үүнд:

- **Ядуурал:** Энэ бол хүний наймаа дэлгэрэх хамгийн том хүчин зүйл юм. Орлого бага, тогтсон ажилгүй байх зэрэг санхүүгийн эмзэг байдал нь хүний наймаачдын хохирогчийг олзлох гол хүчин зүйл болохын хажуугаар хүний наймаанд өртөх бусад эрсдлийг нэмэгдүүлэх суурь шалтгаан болж байдаг.
- **Авлига:** Тухайн улсын хөгжилд зарцуулагдах ёстой хөрөнгө баялаг авлига хэлбэрээр гадагш эсвэл хэн нэгний хувийн ашиг сонирхолд зарцуулагдсанаар улс орныг хөгжих боломжид саад учруулж улсын эдийн засаг, улс төр, хүн амыг уналтад оруулахад нөлөөлдөг. Үүнээс үүдэн тухайн улсын иргэд амьдралаа дээшлүүлэх зорилгоор нүүдэллэх, эрсдэлт боломжийг эрэлхийлэхэд түлхэгдэж байдаг байна.
- **Тэгш бус байдал:** Нийгмийн болон эдийн засгийн тэгш бус хөгжил нь иргэдийг илүү дээр амьдралын боломжийг эрэлхийлэх зорилгоор албан болон албан бус шилжилт хөдөлгөөн хийхэд хүргэдэг. Эрүүл мэнд, боловсрол, төрийн үйлчилгээ зэрэг нийгмийн суурь үйлчилгээ амьдарч буй газар нь хүртээмжгүй байх, ажил хөдөлмөр эрхлэх, зах зээлд шударгаар оролцох, үнэлүүлэх боломж бүрдээгүй газраас иргэд илүү дээр боломжийг эрэлхийлэх зорилгоор шилжих сонголтыг хийж байгаа нь иргэдийн эмзэг байдлын суурь шалтгаануудын нэг мөн.
- **Зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах тогтолцоо сул:** Олон улс оронд нийгмийн эмзэг, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хангах, хамгаалахад тогтолцоо нь хүрч үйлчилж чаддаггүйгээс тэднийг олон талаар хамгаалалтгүй нөхцөлд үлдээж, гэмт хэргийн хохирогч болон холбогдогч болоход хүргэдэг. Үүнд нөлөөлдөг хамгийн том хүчин зүйл нь улс орнуудын хүний эрхийн талаар суурь хууль тогтоомжгүй эсвэл хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудал байдаг. Хүний эрхийн хуульгүй байдал нь хүний наймаа болон бусад төрлийн гэмт хэрэг гарах нөхцлийг бүрдүүлэхээс гадна түүнтэй тэмцэх механизмыг үгүйсгэж байдаг.
- **Боловсролын хүртээмжгүй байдал:** Боловсрол бол нийгмийн амьдралын баталгаа. Боловсролын түвшин бага байх нь хөдөлмөр эрхлэх боломжийг бууруулах, төрийн үйлчилгээ авч чадахгүй байх, өөрийгөө хамгаалах болон эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрхээ хамгаалах чиглэлд бүх түвшинд хариу үйлдэл үзүүлэх, нийгэмд зохистой түвшинд аж төрөх нөхцлийн суурь баталгаа болж байдаг.
- **Хууль бус шилжилт хөдөлгөөн:** Аюулгүй байдал, эдийн засгийн боломжоос хамаараад эх орноосоо дүрвэх хүсэлтэй хүмүүс нь хүний наймаачдын зорилтот бүлэг. Шилжин суурьшигчдын хувьд амьдрах орон байр, ажил хөдөлмөр, зэрэг суурь хэрэгцээгээ хангах хэрэгцээ өндөр байх энэ хэрэгцээг нь хүний наймаачид далимдууллаг. Ажил хайж байгаа цагаачдын хувьд гэмт хэрэгтнүүд ихэвчлэн тэдэнд хууль ёсны мэт санагдах ажлыг санал болгодог байна.
- **Зөрчил мөргөлдөөн болон байгалийн гамшигт үзэгдэл:** Нийгмийн урт хугацааны макро хүчин зүйлсээс гадна гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс болох байгалийн гамшиг эсвэл улс төрийн зөрчилдөөн маргаан, иргэний дайн зэрэг нь нийгмийн тогтворгүй байдал үүсгэх, үймээн самуун дэгдэх, хүний эрхийн зөрчлийг үл хайхрах нөхцлийг бүрдүүлж, хүний наймааны гэмт хэрэгтнүүдэд таатай нөхцлийг бүрдүүлж байдаг. Зөрчил, мөргөлдөөн, дайнтай бүс нутагт насанд хүрээгүй хүүхдүүдийг цэрэг дайны үйл ажиллагаанд татан оролцуулах, ачаа зөөгч, тагнуулч, мэдээ дамжуулагч, амиа золиослогч, секс боол болгох зэргээр ашигладаг байна. 2017 оны байдлаар НҮБ-с хүүхдийг цэргийн зорилгоор ашиглаж буй 14 улсыг нэрлэсэн ба ойролцоогоор 100,000-с илүү хүүхэд энэ төрлийн хүний наймаанд өртөж байгаагийн 40 хувь нь охидууд байна¹¹².


111 https://www.traffickinginstitute.org/wp-content/uploads/2017/06/Root-Cause-2-pager_web.pdf

112 <https://www.mei.edu/publications/begin-children-child-soldier-numbers-doubled-middle-east-2019>

- **Хямд хөдөлмөр, бэлгийн мөлжлөгийн эрэлт хэрэгцээ:** Хүмүүсийн хэрэглээн дээр суурилсан эдийн засгийн эргэлт нь хүний наймааны ашгийг нэмэгдүүлж, цэцэглэн хөгжих шалтгаан болсоор ирсэн. Хэрэглэгчид, ялангуяа хөгжингүй улс орны хэрэглэгчид нь бэлгийн үйлчилгээ болон бараа бүтээгдэхүүний харьцангуй хямд үнэтэйг сонгож, их хэмжээний эрэлтийг бий болгож байдаг. Үүний дүнд хэрэглэгчид нь өөрсдийн мэдэлгүйгээр хүний наймааны хохирогчдыг худалдаж авах, боолчлолын замаар үйлдвэрлэсэн хямд/хямдавтарт бүтээгдэхүүний эрэлт үүсгэж, уг зах зээлийг үргэлжлүүлэн амьдрүүлсаар байна¹¹³.
- **Хүний наймаачид:** Дээр дурдсан нийгэм, соёл, улс төрийн олон хүчин зүйл иргэдийг хүний наймааны хохирогч болох эрсдлийг нэмэгдүүлэхээс гадна ямар ч маргаангүй нэг шалтгаан бол хувийн ашиг сонирхлын төлөө бусдыг золиослох сонголтыг хийж буй гэмт этгээдүүд. Хүний наймааны шалтгаан нөхцлийг дурдсан олон судалгааны ажилд тус гэмт хэрэг нь харьцангуй бага эрсдэлтэй тулгарахын зэрэгцээ ашиг их олж, түүнийг хууль ёсны эдийн засагт бэрхшээл, хаалт багатайгаар хөрвүүлэх боломжтой (ялангуяа мөнгө угаахтай тэмцэх систем сул орнуудад) байх нь гэмт хэрэгтнүүд тус хэргийг үйлдэх гол шалтгаан гэж үздэг боловч эцсийн дүндээ ашиг орлогын төлөө бусдыг мөлжих сонголтыг хийж буй ёс суртахуун, хүнлэг сэтгэлийн доройтолд орсон бүлэг хүн амын дунд олшрох нь өөрөө хүний наймаа үйлдэгдэх нэг шалтгаан маргаангүй мөн.

Харин Монгол Улсад хүний наймааны гэмт хэрэг үйлдэгдэх, өсөн нэмэгдэхэд дараах нийгэм, эдийн засаг, улс төрийн шалтгаанууд голлон нөлөөлж байна.

1. Авлига, ашиг сонирхлын зөрчил. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг нь олж буй ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд албан тушаалтнуудыг авлигад автуулах явдал байсаар байгаа нь манай улсад хүний наймаа үйлдэгдэх, илрэхгүй байх хамгийн том шалтгааны нэг болж байна. Тухайлбал, хилийн хяналт хийх үүрэг бүхий хүмүүс нь энэ үүрэгтээ хайхрамжгүй хандаж хохирогчдын хууль бус бичиг баримтыг үл анзааран хил нэвтрүүлэх байдал байна. Улс орнуудын төрийн байгууллага дахь авлигын нөхцөл байдлыг тодорхойлдог “Транспэрэнси Интернэшнл”-ын Авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 2021 онд 180 орноос 35 оноо авч, 110-д эрэмбэлэгджээ¹¹⁴.



Монгол Улсын индексийг тооцоход нийт 8 эх сурвалжийг ашигласан бөгөөд Дэлхийн эдийн засгийн форумын Үзэл бодлын судалгаа болон Дэлхийн эрх зүйн төслийн Хууль дээдлэх ёсны индекс тус тус өссөн үзүүлэлттэй гарсан нь өмнөх оноос 1 байраар урагшлах боломжийг бий болгожээ¹¹⁵.

Төрөөс авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох чиглэлд анхаарч эрх зүйн орчныг бүрдүүлж, 2012 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталсан боловч

113 Үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэг, ялангуяа хүн худалдахын эдийн засгийн логик, зах зээл хоорондын онцлог, С.Энхчимэг,
 114 <https://iaac.mn/post/104312>
 115 <https://iaac.mn/post/104312>

түүнийг сахин биелүүлэх үүрэгтэй төрийн албан хаагчид зарим тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсгэх, албан үүрэгтэй хайнга хандах явдал байсаар байгаа юм.

...“Манай аавын ахынх хүү Г над руу залгаад Замын-Үүдийн хилээр 2 хүн гарах гэсэн чинь цагаан хуудас авах хэрэгтэй болчоод байна гээд над руу яриад байна, чи хил хамгаалах газарт ажилладаг юм чинь тэр хоёр хүнд цагаан хуудас авахад нь туслаач гэсэн. Ахынх нь танил сайн хүмүүс байгаа, ямар нэг асуудал байхгүй, чи хүнээс асуугаад туслаад өгөөч гэсэн. Тэгэхээр нь би Замын-Үүдийн хилийн ... дугаар ангийн ... -ны дарга руу залгаад манай хамаатны хүний ажлынх нь 2 хүн хилээр гарах гэсэн чинь цагаан хуудас хэрэг болоод байна гэнэ, та тус болооч гэж гуйсан. Тэгээд тэрнээс хойш юу болсныг нь мэдээгүй. Ямар ч байсан нөгөө 2 хүн нь цагаан хуудсаа очиж аваад хилээр гарсан байх.

Хавтаст хэргийн судалгааны материалаас

2. Ядуурал буюу эдийн засгийн хязгаарлагдмал байдал. Ядуурлын төлөв байдлыг илтгэх улсын хэмжээний тоо баримтуудыг авч үзвэл ҮСХ, Дэлхийн Банк хамтран гүйцэтгэсэн Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны дүнгээр Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2018 онд 28.4 хувь байсан бол 2020 онд 27.8 хувь болж, 0.6 пунктээр буурч, ойролцоогоор нийт хүн амын 903.4 мянга нь ядуу амьдарч байна. Байршлаар харвал хот суурин газарт 2018-аас 2020 онд ядуурлын түвшин 0.7, хөдөө орон нутагт 0.3 нэгж хувиар буурсан байна. Нийт амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой хүн амын 64 хувь нь хот суурин газарт, үүнээс 43 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

ҮСХ-ны тайланд дурдсанаар ядуурал бага насны хүүхдийн дунд зонхилж байгаа нь анхаарал татаж байна. Монголд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхэд байна. Ядуурал өрх дэх хүүхдийн тоо, тэжээгчдийн хувьтай нягт хамааралтай байгаа нь үр хүүхдүүдээ тэтгэх хангалттай тооны хөдөлмөрийн насны хүмүүс дутагдалтайн тусгал болж байна. Тэгвэл ядууралд өссөн хүүхдүүдийн хувьд боловсрол эзэмших боломж бага¹¹⁶, үүнийг дагаад хүрэлцээтэй цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж буурах, энэ нь эдийн засгийн аливаа боломжийн төлөө иргэд өөрсдийгөө эрсдэлд оруулах магадлалыг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.

3. Шилжилт хөдөлгөөн. Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөн нь 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш эрчимтэй явагдаж эхэлсэн. Шилжилт хөдөлгөөний урсгалыг харвал хот суурин газар уруу, ялангуяа, нийслэл Улаанбаатар хот руу шилжин суурьшиж буй өрхүүдийн эзлэх хувь өндөр бөгөөд энэ нь хотжилтын түвшинг нэмэгдүүлж, хөдөө орон нутгийн зарим хэсэгт хүн амын хэт цөөрөлтийг бий болгож байна.

Хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн 2010 онд дээд цэгтээ хүрч байсан бөгөөд түүнээс хойш ч гэсэн урсгал өндөр хэвээр буюу 2017 он хүртэл жилд дунджаар 30,000 хүн Улаанбаатар хотод шилжин суурьшсан байна. Хүн амын хэт төвлөрлийг барих зорилгоор 2017 оны 1 сард Нийслэлийн Засаг дарга Улаанбаатар хот уруу чиглэсэн дотоодын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах захирамжийг гаргасантай холбоотойгоор тус оноос хойш албан шилжин ирэгсдийн тоо огцом буурсан.

Захиргааны бүртгэл мэдээллийг харвал тус шийдвэр нь нийслэл хот уруу зорих шилжилт хөдөлгөөний урсгалыг бууруулсан мэт харагдах боловч тус хоригоос шалтгаалан шилжин

116 “Монгол Улсын боловсролын тогтолцоонд тэгш бус байдал газар авч байгааг олон судалгаа дурддаг ба хүүхдүүд хаана, ямар гэр бүлд өсч байгаагаас хамаарч боловсролын үлэмж ялгаатай орчинд суралцаж байна”. Боловсролын тэгш бус байдал ардчиллын өөрийнх нь хувь заяатай холбоотой асуудал, МУИС-ийн багш, Социологийн ухааны доктор Г. Түмэннаст, 2020

ирэгсдийн хувьд өргөн хүрээний олон асуудал бэрхшээлтэй тулгарах болсныг ОУШХБ-ын судалгааны тайлан¹¹⁷-д дурджээ.

Улаанбаатар хотод шилжин суурьшихыг хориглосон 2017 оны шийдвэртэй холбоотойгоор нийслэлийн иргэнээр бүртгүүлэх, амьдрах газрын зөвшөөрөл авах, орон сууц, ажлын байр олоход бэрхшээлтэй болж, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдан, улмаар нийгэм, эдийн засгийн амьдралаас тусгаарлагдах, гадуурхагдах зэрэг хүндрэлүүд нийтлэг тулгамдсан асуудал болжээ. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор үүсэж буй дээрх асуудлууд иргэдийн эмзэг байдалд хэрхэн нөлөөлж буйг авч үзвэл:

- Шилжигчдийн дийлэнх нь 25–39 насны залуучууд ба хөдөлмөрийн нөхцлөө сайжруулах боломжийг эрэлхийлэн уугуул нутгаа орхиж явж байна. Гэвч хөдөлмөрийн зах зээлийн албан секторт ажлын байр харьцангуй хомс байгаа учраас тэдний ихэнх нь албан бус секторын тодорхой бус нөхцөлтэй үйл ажиллагаанд оролцож байна.
- Шилжихээсээ өмнө шилжин суурьшсан нутгийнхаа талаар мэдээлэл олж авах байдал хязгаарлагдмал. Шилжигч өрхүүдийн дийлэнх нь шилжин суурьших гэж байгаа газар нутгийн талаар ямар нэг мэдээлэлгүйгээр шууд шилжин суурьшиж байна.
- Шилжин ирэгсэд нь шилжин суурьшсан нутагт ирсний дараа амьжиргаа/ахуйн нөхцөлтэй холбоотой асуудалтай тулгардгаас гадна шилжин суурьших гэж ирсэн нутагт орон байр болон газрын зөвшөөрөлтэй холбоотой бэрхшээлүүд илүүтэй тохиолддог байна.
- Шилжигч өрхүүдийн дунд шилжих хөдөлгөөний бүртгэлийн түвшин харьцангуй доогуур, энэ нь нэн ялангуяа, Улаанбаатарт хамгийн бага байна. Шилжих хөдөлгөөний бүртгэлгүй шилжигч өрхийн тоо нийслэлд хамгийн өндөр байна.

Илүү дээр амьдралын боломж нөхцлийг эрэлхийлэн шилжилт хөдөлгөөнд орсон хэдий ч албан ёсоор захиргаандаа бүртгүүлж төрийн үйлчилгээ авч чадахгүй байх, албан секторт ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байх, орон байр, газрын эзэмшил, ахуйн нөхцөлтэй холбоотой хүндрэлүүдтэй тулгарч байгаа нь иргэдийг эрсдэлтэй алхам хийхэд нөлөөлөхүйц хүчин зүйл юм. Шилжилт хөдөлгөөн болон Нийслэлийн ядуурлын үзүүлэлтийг харьцуулж үзвэл жил тутам шилжин ирэгсдийн урсгал нэмэгдэх хэрээр Улаанбаатар хотын ядуурлын түвшинд эерэг өөрчлөлт гарахгүй байгаа дүр зураг харагдана. Ядууралтай холбоотой шалтгааныг авч үзсэн өмнөх хэсэгт дурдсанчлан Улаанбаатар хотод нийт ядуу 5 хүн тутмын гурав нь байрлаж байгаа, тэдгээрийн иргэдийн дийлэнх хувийг шилжин ирэгсэнд бүрдүүлж байгааг харгалзвал дотоод шилжилт хөдөлгөөний идэвхтэй урсгал нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх шалтгаануудын нэг болж байна.

4. Боловсролын чанар, хүртээмж. 2020 оны байдлаар манай улсын бичиг үсэг тайлагдалтын түвшин 98,7 хувь¹¹⁸, хүн ам боловсролын түвшингээр гурван хүн тутмын хоёр нь бүрэн дундаас дээш боловсролтой, нэг хүний дунджаар суралцах хугацаа 15 жил¹¹⁹ зэрэг үзүүлэлт нь боловсролын түвшний индекс болон бусад ерөнхий үзүүлэлтээрээ бусад ижил төстэй оронтой харьцуулахад эерэг үр дүнг харуулдаг.


Ерөнхий төлөв байдлаараа боловсролын түвшин нь ядуурлын үзүүлэлттэй харилцан уялдаатай хэвээр байгаа бөгөөд хөвгүүд, тэр дундаа хөдөөгийн хөвгүүд гэр бүлийнхэндээ туслахын тулд сургуулиасаа эрт завсардах хандлагатай, харин охид илүү удаан суралцаж, өндөр боловсрол эзэмших хандлагатай байна.

117 Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа, ОУШХБ, 2018

118 http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0400_068V1

119 Монгол улсын боловсролын статистикийн өнөөгийн байдал, YCX

Гэвч нас болон хүйсийн зарим бүлэгт онцлог ялгаатай үр дүнгүүд ажиглагдах бөгөөд тухайлбал, залуу эмэгтэйчүүдийн (25-29 нас) 70 хувь нь дээд боловсрол эзэмшсэн ч энэ нь тэднийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоход нөлөөлөхгүй байгаа үр дүн гарчээ¹²⁰. Өөрөөр хэлбэл бага боловсролтой байх нь эдийн засгийн хувьд ядуу байх нөхцөлийг бүрдүүлж байгаа хэдий ч дээд боловсрол эзэмшсэн байх нь эдийн засгийн хувьд сайн байх нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.



Хүн худалдаалах гэмт хэрэг нь өөрөө нийгмийн асуудал болохынхоо хувьд уг гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нь улс орон, нийгмийн суурь асуудлуудтай холбогдоно. Түүнээс гадна уг гэмт хэрэгт ямар бүлгүүд илүү өртөмтгий байгаа, тэдгээр иргэдийн өртөх эрсдлийг бууруулах чиглэлд тодорхой ажлуудыг төлөвлөхийн тулд уг гэмт хэргийн хохирогч болоход нөлөөлж буй хүчин зүйлсийг зайлшгүй судалж, тодруулах нь хойшдын ажилд тустай бөгөөд тодорхой мэргэжлийн үйлчилгээг төлөвлөхөд чухал ач холбогдолтой.

2.5

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

ЕАБХАБ-ын ХХГХ-тэй тэмцэх асуудал хариуцсан тусгай төлөөлөгч Мадина Ярбуссинова “Хүн худалдаалахтай тэмцэх асуудлыг Засгийн газрын оролцоотой хийхгүй бол үр дүн гарахгүй бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн асуудлын нэгийг “Хүн худалдаалахтай тэмцэх” болгох шаардлагатай” гэж Монгол Улсад өгсөн зөвлөмждөө цохон тэмдэглэжээ¹²¹. Манай улс энэ чиглэлээр багагүй ажлуудыг хийж, ахиц гаргаж буйн илэрхийлэл нь Хүн худалдаалахтай тэмцэх бие даасан хууль батлагдаж, хуулийн хэрэгжилтийг хангах журмууд батлагдан гарч, үндэсний хөтөлбөртэй болсон явдал юм.


Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд¹²² хохирогчийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрийг хуульчилсан байдаг. Уг хуулийн 12-р зүйлд зааснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид дараах таван төрлийн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхээр тусгажээ. Үүнд:

120 Ядуурлын дүр төрх, УСХ, Дэлхийн банк, 2021

121 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал судалгааны тайлан, УБ.,2021

122 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2012 он, №7

Зураг 17. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчид үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээний төрөл



Эдгээр үйлчилгээг үзүүлэхэд тусгайлсан журам гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих үүргийг төрийн захиргааны төв байгууллагуудад хүлээлгэсэн. Тухайлбал:

1. Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээтэй холбоотой журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэх үүрэгтэй¹²³. Харин энэ журам¹²⁴ нь Гэрч хохирогчийг хамгаалах хуулийн хүрээнд батлагдан гарсан ба энэ нь ХХГХ-ийн хохирогчдод мөн адил үйлчлэх зохицуулалтай байна.

Журмын агуулга нь: ХХГХ-ийн хохирогч болсон, сэтгэлзүйн цочмог болон архаг хариу урвалууд илэрсэн, сэтгэц, зан үйлийн эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн, сэтгэл гутрах ба сэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, дасан зохицохуйн эмгэг, хувирах болон хуваагдах эмгэг, солиорох эмгэгт өртсөн өвчтөнд сэтгэцийн эрүүл мэндийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэхийг зохицуулсан.

2. Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээний журмыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн¹²⁵ ба тус журам нь 2015 онд батлагджээ¹²⁶. Энэ журмын хүрээнд хохирогчийг мэргэжлийн сургалтад хамруулах, хүсэлт гаргасан хүнд төрийн байгууллагын зүгээс хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тусгажээ. Хохирогчийн гаргасан хүсэлтийг эцэслэн шийдвэрлэх эрх бүхий газар нь Хүн худалдаалахтай тэмцэх Дэд зөвлөл байна.

Журмын агуулга нь: Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа ХХГХ-ийн хохирогчийг, онцгой тохиолдолд хохирогчийн хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах, эсхүл ажлын байраар хангах ажлыг Тахарын албатай¹²⁷ хамтран зохион байгуулахаар журамласан.

123 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг
 124 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 462-р тушаал "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх" журмыг баталсан байна.
 125 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг
 126 Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаал "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх" журмыг баталсан байна.
 127 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн Тахарын албаны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдснаар Тахарын албыг татан буулгаж, гүйцэтгэж байсан чиг үүргийг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлсэн.

3. Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам¹²⁸-ыг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гаргах үүрэг хүлээсэн. Мөн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам¹²⁹-ыг Улсын ерөнхий прокурортой хамтран Хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлах бөгөөд тус журам өнөөг хүртэл батлагдаагүй байна. Гэхдээ УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, төлбөрийн чадваргүй иргэн өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авч чадах эрх зүйн орчин бүрджээ.
4. Гадаад улсад Монгол Улсын Консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэх бөгөөд Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 тушаалаар баталсан байна¹³⁰. Журмын хэрэгжилтийг хангах санхүүжилтийн эх үүсвэр нь Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн төрөл болох Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас¹³¹ гаргах зохицуулалттай байна.

Журмын агуулга нь: Хилийн чанадад хүн худалдаалах болон бусад төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын иргэний аюулгүй байдлыг хангах, эрх ашгийг хамгаалах, эх оронд нь буцаах хүртэлх хугацаанд Дипломат төлөөлөгчийн газраас түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах зэрэг хуульд заасан бусад үйлчилгээг үзүүлэхээр зохицуулсан.

“Засгийн газрын тусгай сан” гэдэг нь Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг хэлнэ.

Энэхүү сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах бөгөөд дараах тусгай сангуудтай байна. Үүнд:

- ✓ Байгаль орчин, уур амьсгалын сан;
- ✓ Боловсролын зээлийн сан;
- ✓ Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан;
- ✓ Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан;
- ✓ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;
- ✓ Засгийн газрын нөөц сан;
- ✓ Ирээдүйн өв сан;
- ✓ Кино урлагийг дэмжих сан;
- ✓ Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан;
- ✓ Нийгмийн даатгалын сан;
- ✓ Нийгмийн халамжийн сан;
- ✓ Соёл, урлагийг дэмжих сан;
- ✓ Спортыг дэмжих сан;
- ✓ Төсвийн тогтворжуулалтын сан;
- ✓ Улсын авто замын сан;
- ✓ Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан;
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;
- ✓ Хөдөө аж ахуйг дэмжих сан;
- ✓ Шинжлэх ухаан, технологийн сан;
- ✓ Эрүүл мэндийг дэмжих сан;
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сан;
- ✓ Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан;
- ✓ Хүүхдийн төлөө сан;

128 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг

129 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь хэсэг

130 Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91-р тушаал “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх” журмыг баталсан байна.

131 Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2019, №48

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлд Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн талаар заасан бөгөөд Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан нь хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлэх, иргэний улсын бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зориулалттай байна.

Энэ сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулахаар хуульд заасан байна.

Үүнд:

- хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, терроризм, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах;
- гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах;
- дээр дурдсан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;
- хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль, хяналтын байгууллагаар шалгуулах, хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх зэрэг зардалд зарцуулна.

Мөн манай улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, туслалцаа үйлчилгээ үзүүлэх чиглэлээр дараах стандартууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна¹³².

1. Стандарт, хэмжил зүйн газраас “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6418:2013)-ийг баталсан. Стандартын зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, уг үйлчилгээний орчныг тодорхойлох, улмаар үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд оршино. Энэ стандартад ХХГХ-ийн хохирогчийг тогтоох маягт (хавсралт №3-аас үзэх), хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээний үе шатуудад тавигдах шаардлагыг тогтоосон.
2. Стандарт, хэмжил зүйн газраас 2009 онд батлагдсан Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS6040:2009) стандартыг 2016 онд шинэчилэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэх зорилгоор 2019 онд “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6040:2019) стандартыг баталсан. Стандартын зорилго нь хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах, тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтоож мөрдүүлэхэд оршино. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагааг хүний эрхэд суурилан зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үйлчилгээний явц, чанар, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдалд хяналт тавих, үнэлэх, магадлан итгэмжлэхэд хэрэглэхээр зохицуулсан байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6418:2013) стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-уудад хамаарах зохицуулалттай ба онцлог нь хамгаалах байрны үйлчилгээг

132 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал судалгааны тайлан, УБ.,2021

дөрвөн төрөлд хуваан үзсэн ба эдгээр байраар үйлчлүүлэх тохиолдолд тус бүртээ өөр өөрийн хугацаатай байхаар зохицуулжээ. Тухайлбал,

1. Яаралтай тусламж үзүүлэх хамгаалах байр нь хохирогчид эрүүл мэнд, аюулгүй байдал болон бусад яаралтай тусламж, үйлчилгээг дараагийн шатны буюу түр болон урт хугацааны хамгаалах байр болон өөр бусад үйлчилгээнд шилжүүлэхээс өмнө 7 хүртэлх хоногоор байрлуулах газрыг;
2. Дамжих байр нь хохирогчийг 5 хүртэл хоногоор байрлуулан, аюулгүй байдлыг хамгаалж, энэ хугацаанд түүнд дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий газрыг;
3. Түр хугацааны хамгаалах байр нь хохирогчийг 3 хүртэл сар байрлуулж, түүний аюулгүй байдлыг хамгаалж, улмаар эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх газрыг;
4. Урт хугацааны хамгаалах байр нь удаан хугацаагаар үйлчлүүлэх шаардлага бүхий хохирогчид 3-6 сарын хугацаанд эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх газрыг ойлгоно гэжээ.

Эндээс үзэхэд хамгаалах байрны төрлөөс хамаарч хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хугацаа зохицуулагдаж байна. Мөн түүнчлэн хохирогчдод үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын хувьд хамгаалах байрны үйлчилгээ үзүүлж байгаа Талита-Ази, ХТЭТ, ХЭҮТ-ийн хамгаалах байрууд нь түр болон урт хугацааны хамгаалах байрны статусаар хохирогчийг хүлээн авснаас эхлээд гурван сараас дээш хугацаагаар үйлчилгээ үзүүлдэг байна. Эдгээр байруудад ХХГХ-т өртсөн хохирогч хүүхдийг насны хязгаартайгаар байрлуулдаг ба 16 наснаас дээш хохирогч хүүхдийг эцэг, эхийн зөвшөөрөлтэйгээр байрлуулдаг.

Стандартад зааснаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хохирогчид үзүүлэх нийтлэг үйлчилгээнд хохирогчийг хүлээн авах, тодорхойлох, яаралтай үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө боловсруулах, хохирогчийн түүхийг хаах, хохирогчоос утсаар мэдээлэл авах, зөвлөгөө өгөхийг багтаажээ.

Хохирогчид нөхцөл байдлаасаа хамааран дараах таван төрлийн үйлчилгээнд хамрагдахаар тусгажээ.

Гэвч энэ стандартыг зөвхөн ТББ-ын үйл ажиллагаа, тэднээс үзүүлж буй үйлчилгээнд баримтлахыг шаардсанаар төрийн байгууллагын үйлчилгээнд хамааралгүй болж, өргөн хүрээнд ашиглах боломжийг хязгаарласан байдаг.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хууль, стандартаар хүлээсэн үүргээ биелүүлж, өөрсдийн үйл ажиллагааны цар хүрээнд багтаан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж илрүүлэх, тэдэнд шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлж байгаа бөгөөд тэдний үйл ажиллагааг Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал судалгааны тайланд дараах зураглалаар харуулжээ.

Зураг 18. ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх тусалцаа, үйлчилгээний төрөл



Зураг 19. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тэдэнд шаардлагатай дэмжлэг тусалцаа үзүүлэх зураглал



Үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын мэдэгдснээр ХХГХ-ийн хохирогчид хэвийн амьдралдаа эргэн орж, нийгэмшихэд дараах асуудал нийтлэг тохиолдож байгаа бөгөөд ТББ-ууд доорх байдлаар туслалцаа, үйлчилгээ үзүүлж байна гэжээ¹³³.

Хүснэгт 11. ТББ-уудаас хохирогчид тулгамдаж буй асуудал болон түүнийг хэрхэн шийдвэрлэж буй талаарх мэдээлэл

Тулгамдаж буй асуудал	Шаардлагатай үйлчилгээ
Санхүү: Орлогын эх үүсвэргүйгээс болж бусдаас хараат байдал ордог. Иймээс биеэ даан амьдрахад хүндрэлтэй байдаг.	Туслалцаанд хамрагдах: Эргэн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжтой. Мөн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтаа амжилттай дүүргэсэн тохиолдолд ажлын байранд хэрэгцээт анхан шатны тоног төхөөрөмжийн тусламж, дэмжлэгт хамрагдах боломжтой.
Айдас: Гэмт хэрэгтнүүдээс айх айдсаас гадна бусад хүмүүс энэ талаар мэдсэн байх вий, олон нийтийн сүлжээнд мэдээлэл тарчих вий гэсэн айдас, туслалцаанд хамруулж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарчих болов уу гэсэн эргэлзээ, айдас бий.	Өмгөөлөгчтэй байх: Гэмт хэрэгтнүүдээс ирэх дарамтыг бууруулах, цагдаагийн байгууллагад мэдээлж аюулгүй байдлыг хангуулах, хохирогчийн эрхийг хамгаалахад хамтран зүтгэгч болдог.
Гэр бүл, найз нөхдийн харьцаа, хандлага: Хохирогчдод тулгарч буй бэрхшээлийн голлох хэсэг нь ар гэр, найз нөхдийн харьцаа, хандлагад гарч буй өөрчлөлт байдаг. Ар гэрийнхэн нь гэрээс гарч, орох, бусадтай холбоо тогтоох бүх үйлдэлд хяналт тавих, оролцох, хориглох бол найзууд зайгаа барих, эсвэл бусдадаа худал мэдээлэл дамжуулах зэргээр харьцаа, хандлага өөрчлөгддөг	Ар гэрийнхэнтэй нь ойлголцуулах: Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн оролцоотойгоор хохирогчийг (насанд хүрсэн бол өөрийнх нь хүсэлтээр) ар гэрийнхэнтэй нь ойлголцуулж өгөх, хэвийн амьдралдаа эргэн ороход нь туслалцаа үзүүлдэг.
Гэр бүлийн орчин: Эмзэг байдал нь арилахгүй байх, хохирогчийг буруутгах хандлага гарах, эсвэл гэрт хамт амьдрах боломжгүй, хүчирхийлэл дарамттай байх, өнчин болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй байх зэрэг асуудлууд.	Сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө: Зөвлөгөө өгөх, мэргэжлийн чиг баримжаатай болгох, ажилд зуучлах зэргээр эмзэг байдлыг бууруулах, нэн шаардлагатай тохиолдолд орон гэртэй болоход туслах, жижиг гарааны бизнес эрхлэхэд туслах зэргээр эмзэг байдлыг бууруулах оролдлого хийгддэг.

Дээрх нөхцөл байдлаас харвал ХХГХ-ийн хохирогчдод аюулгүй байдлын хамгаалалт, эдийн засгийн бие даасан байдал, бусдаас хараат бусаар амьдрах нөхцөл боломж, удаан хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ, амьдрах орон байр зэрэг нь тулгамдсан асуудал байсаар байна.


Иймээс төр, ялангуяа анхан шатны нэгжид ажиллаж буй төрийн албан хаагчид энэхүү байдлыг соргогоор мэдэрч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан төрийн чиг үүрэгт хамаарах туслалцаа дэмжлэгийг цаг алдалгүй үзүүлэх, бусад байгууллагад холбон зуучлах ажлыг хийж гүйцэтгэх ёстой.

Өөрөөр хэлбэл хохирогчийн хувийн байдал, өөрийн хүсэл эрмэлзэл, саналыг харгалзан мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байранд холбон зуучлах, шаардлагатай тохиолдолд бичил зээлд хамруулж, өөрийн гэсэн жижиг, дунд бизнес, орлоготой болоход дэмжлэг үзүүлэх шаардлагатай юм.

133 Хүйсийн тэгш эрхийн төв, ТББ, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал судалгааны тайлан, 2021

Зураг 20. Хохирогчид шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх, холбон зуучлах зураглал

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх, холбон зуучлахдаа дараах үе шатыг баримтлана. Үүнд:



Иймээс анхан шатны нэгжид ажиллаж буй мэргэжилтнүүд хүн худалдаалах гэмт хэрэг, түүний төрөл, хэлбэр, хор уршгийн талаар ойлголттой мэдлэгтэй байхын зэрэгцээ, хохирогч төвтэй, хүний эрхийн мэдрэмжтэй байх зайлшгүй шаардлагатай юм.

Ингэснээр дээр үзүүлсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх, холбон зуучлах зураглалын дагуу ажиллаж, хохирогчийг хамгаалах бүрэн боломжтой болохыг онцлоё.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон дээр дурдсан 2 стандартын хүрээнд хамгаалах, үйлчилгээ үзүүлэхээс гадна бусад хуульд заасан хамгааллын арга хэмжээнд хамруулах, үйлчилгээ үзүүлэх боломжтой юм. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн¹³⁴ 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед энэ хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд¹³⁵ заасан гэрч, хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалт, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд орох хүсэлтийг гаргах эрхтэй.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтад нийт 11 арга хэмжээг хуульчилахын зэрэгцээ хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах дөрвөн төрлийн үзүүлэх туслалцаа үзүүлэх зохицуулалттай байна.

1. Хууль зүйн туслалцаа
2. Сэтгэл зүйн туслалцаа
3. Эрүүл мэндийн туслалцаа
4. Нийгмийн бусад туслалцааг¹³⁶ үзүүлэх зэрэг юм.

Эдгээр үйлчилгээнээс хууль зүйн болон сэтгэл зүйн туслалцаа, эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ. Харин нийгмийн бусад туслалцааг үзүүлэх үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх зохицуулалттай. Тус хуулийн хүрээнд хохирогч, гэрч нарт үзүүлэх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлт хяналт тавих чиг үүргийг холбогдох байгууллагуудад хүлээлгэсэн байна. Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийг даган гарсан дараах журмууд байна.

¹³⁴ Төрийн мэдээллийн эмхтгэл, 2017 он, Дугаар 23

¹³⁵ Төрийн мэдээллийн эмхтгэл, 2013 он, Дугаар 30

¹³⁶ Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн тайлбарт Нийгмийн бусад туслалцаа гэж хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн амьдралын зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, хувцас, шаардлагатай бусад ахуйн хэрэгцээ болон насанд хүрээгүй гэрч, хохирогчийн суралцах хэрэгцээг хангахад чиглэсэн төрөөс үзүүлж байгаа тусламж үйлчилгээг ойлгоно.

- Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам¹³⁷,
- Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам¹³⁸,
- Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам¹³⁹

2.5.1. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээ

Хүүхэд бүр аливаа хүчирхийллээс ангид аюулгүй орчинд өсч хөгжих эрхтэй гэж НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан. Хүн бүрийн эдлэх ёстой үндсэн эрхүүдийн нэг болох аюулгүй байдлаа хамгаалуулах эрх нь хүүхдийн хувьд хамгийн чухал эдлэх ёстой эрх мөн.

Манай улс уг конвенцод 1990 онд эхний хорин улсын тоонд багтан нэгдэн орсон бөгөөд конвенцын бүхий л заалтууд, ялангуяа хүүхэд бүрийн эсэн мэнд амьдрах, хөгжих, нийгмийн амьдралд оролцох, хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах үүргийг НҮБ болон олон улсын өмнө хүлээн зөвшөөрсөн¹⁴⁰.

Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай конвенц¹⁴¹ болон Палермогийн протоколд нэгдэж орсны хувьд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийг хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон тэдгээрийг дагаж гарсан хэм хэмжээ тогтоосон актууд үйлчилж байна.

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр 2015 онд шинэчилэн найруулсан Эрүүгийн хуульд¹⁴² хүүхдийн эсрэг гэмт хэргийг бие даасан бүлэг болгон, 2016 онд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд¹⁴³ хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтыг тус тус хуульчилсан. Эрх зүйн шинэчлэлийн дүнд хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулийн хүрээнд баталгаажуулснаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хориглосон улс болсон.¹⁴⁴

ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдүүдийн хувьд гэмт хэрэг үйлдэгчид, зуучлагч эсвэл хүлээн авагчдын зүгээс ирэх бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны болон улмаар тарчлаах үйлдлийн хохирогч болсон байдаг нь дээрх төрлийн гэмт хэргийн хохирогчдод тусгайлан хамгаалуулах, урт хугацаанд нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, шаардлагатай хэрэгцээг нь хангах онцгой шаардлага тулгардаг тул ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдүүдэд хохирогч хамгааллын тусгай бодлого, зохицуулалтыг бий болгох нэн шаардлагатай байхын зэрэгцээ үйлчилгээ үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүд тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүүхдийн эрхийн мэдрэмжтэй байх нь чухал юм.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар цагдаагийн байгууллага болон хамгаалах байрны ажилтан нь ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдийн эцэг, эхийг нэн даруй олж тогтоох арга хэмжээ авахын зэрэгцээ хамгаалах байранд байрлуулахдаа насанд хүрсэн хүмүүсээс тусад нь байлгах бүх арга хэмжээг авч, аюулгүй байдлыг хангана.

137 Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал

138 Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаал

139 Хууль зүйн сайдын 2014 оны А/112, А/113, А/114 дүгээр тушаал, Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 дүгээр тушаал

140 Хүүхдийг ивээх сан, Хамтарсан багийн гишүүдэд зориулсан гарын авлага, УБ.,2016

141 Монгол улс нь 1990 оны 1-р сарын 26нд гарын үсэг зурж, 1990 оны 07-р сарын 05-д соёрхон баталсан.

142 Төрийн мэдээлэл эмхтгэл, 2016 он, Дугаар 07

143 Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017 он, Дугаар 05

144 Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, хуудас 1.


Ийнхүү эцэг эхийг нь олж тогтоох ажиллагаанд төрийн анхан шатны нэгжид ажиллаж буй албан хаагчид албан үүргийнхээ чиглэлээр дэмжлэг үзүүлэх ёстой бөгөөд эцэг эх нь олдоогүй бол түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилж, хохирогч хүүхдийг зохих шатны сургуульд хамруулах үүргийг хүлээнэ.

Харин Хүүхэд хамгааллын тухай хуульд гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд тусалж, дэмжих чиглэлээр дараах үйлчилгээг үзүүлнэ гэж заасан. Үүнд:

1. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах
2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх
3. Аюулгүй байдлыг хангах
4. Дэмжих, холбон зуучлах
5. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх
6. Гэр бүлд нь эргэн нэгтгэх

Хүүхдийн эрхийн тухай конвенци, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хүүхдийг гэр бүл болон нийгмийн бүхий л орчинд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, санхүүжүүлэхтэй холбоотой асуудлыг Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмаар зохицуулах бөгөөд энэхүү журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаалаар баталсан байна.

Зураг 21. Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин¹⁴⁵



145 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам

Мэдээлэл авах, илрүүлэх шалгах ажиллагаа

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч¹⁴⁶ хүлээн авч шалгана. Үүнд:

1. Мэдээллийг хүлээн авсан албан тушаалтан тухайн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж, холбогдох тэмдэглэлийг нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлнэ.
 - Мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, үйлдэхэд оролцсон, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ.
 - Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ хуульд заасан тусгаарлах арга хэмжээг авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй.
2. Хэрэв хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй бол цагдаагийн байгууллага, зөрчлийн шинжтэй хүүхдийн эрхийн ажилтан хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж, энэ тухай хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагад мэдэгдэнэ.

Нөхцөл байдлын үнэлгээ хийх

Аливаа хэлбэрийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртөж хохирсон, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан өөрийн санаачилгаар, эсхүл хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэх явцдаа холбогдох этгээдээс ирүүлсэн мэдээ, мэдээллийг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/120, А/178 дугаар тушаалаар батлагдсан Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг баримтлан үнэлгээ хийнэ. Нөхцөл байдлын үнэлгээ нь хүүхдийн амьдарч байгаа орчин, хүүхдэд үүссэн нөхцөл байдал, хүүхдийн эрхийн эсрэг үйлдэл, эс үйлдэхүйн аюул, эрсдэлийн түвшинг үнэлэх, шалгах, дүгнэх гэсэн 3 үе шатнаас бүрдэнэ.

Нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийх явцдаа тухайн асуудлыг газар дээр нь болон хуульд заасны дагуу холбогдох этгээдээр шийдвэрлүүлэх үндэслэлтэй бол хүүхдэд хувийн хэрэг нээж, зөвлөгөө өгөх, дэмжих, холбон зуучлах үйлчилгээнд хамруулна. Ийнхүү нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ хохирогчид гэм хор учруулсан эсхүл учруулсан байж болзошгүй хүнтэй нэг дор байлгах, хохирогчийг буруутгах, тулгах, хөтлөх асуулт тавихыг хатуу хориглохыг анхаарах учиртай.

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг харгалзан хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнээс гадна хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авч болно. Ингэхдээ хамтарсан баг, нийгмийн ажилтны гаргасан дүгнэлтийг заавал харгалзан үзнэ. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ гэдэг нь эцэг эхийн хайр халамжаас гадуур байгаа хүүхдэд урт болон богино хугацаагаар асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг хэлнэ¹⁴⁷.

¹⁴⁶ Хууль сахиулагч - цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно. Гэхдээ энэ тохиолдолд анхан шатны нэгжид ажиллаж буй цагдаагийн алба хаагч гэдэг утгаар хэрэглэнэ.

¹⁴⁷ Стандарт, хэмжил зүйн газар, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 5852:2017) стандарт

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг төрийн байгууллага, эсхүл магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч, хуулийн этгээд, гэр бүл, иргэн үзүүлж болох бөгөөд тэдгээр нь Стандарт, хэмжил зүйн газраас баталсан Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 5852:2017) стандартыг ягштал баримтлах үүрэг хүлээнэ.

Дэмжих, холбон зуучлах үйлчилгээ

Эрх бүхий албан тушаалтан, хамтарсан багаас хийсэн нөхцөл байдлын үнэлгээгээр хохирогч хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай гэж үзсэн бол иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээг нийгмийн ажилтан хариуцан зохион байгуулна.

Хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтан, алба хаагч дэмжих, холбон зуучлах үйлчилгээг үзүүлээгүй, эсхүл шаардагдах үйлчилгээг үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол энэ тухай хүүхдийн эрхийн ажилтан тэмдэглэл үйлдэж, төрийн албаны салбар зөвлөл, мэргэжлийн ёс зүйн хороонд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлдэг. Үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байж хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэхээр заасан.

Энэ нь хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээний үе шатыг зааж оруулсан боловч ямар төрлийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ хэн үзүүлэх талаарх тусгайлан зохицуулалт хангалтгүй байна. Мөн бодит байдалд эдгээр үйлчилгээг мэргэжлийн хүний нөөцөөр хүргэж чадахгүй байгаа нь үйлчилгээний үр дүнд нөлөөлдөг гол асуудал байна.

ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдүүдийн хувьд гэмт хэрэг үйлдэгчид, зуучлагч эсвэл хүлээн авагчдын зүгээс ирэх бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны болон улмаар тарчлаах үйлдлийн хохирогч болсон байдаг нь дээрх төрлийн гэмт хэргийн хохирогчдод тусгайлан хамгаалуулах, урт хугацаанд нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, шаардлагатай хэрэгцээг нь хангах онцгой шаардлага тулгардаг тул ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдүүдэд хохирогч хамгааллын тусгай бодлого, зохицуулалтыг бий болгох нэн шаардлагатай байдаг.


Монгол Улсад ХХГХ-т хохирсон хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээ, түүний төрөл, хэлбэрийн талаарх мэдээллийг нэгтгэн үзүүлбэл¹⁴⁸:

№	Байгууллагын нэрс	Үйлчилгээний төрөл, хэлбэр	Үйлчилгээний үе шат
1	Гүүд нэйборс ОУТББ	- Сэтгэл зүйн зөвлөгөө, засал	- Илрүүлэх - Нөхцөл байдлын үнэлгээ хийх - Холбон зуучлах - Гэр бүлд нэгтгэх
2	Анбаунд Монгол ТББ	- Анхан шатны туслалцаа - Түрээсийн байр - Аюулгүй газраас хангах - Хоол хүнс, хувцсаар хангах - Гэр бүл рүү буцаах	- Илрүүлэх - Холбон зуучлах - Гэр бүлд нэгтгэх
3	Иргэдэд туслах хүний эрхийн төв	- Хууль зүйн туслалцаа	

148 Дэлхийн зөн Монгол ОУБ-ын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ.,2021

4	Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ	– Сэтгэл зүйн зөвлөгөө, засал	– Кейс менежментийн үйлчилгээний тогтолцоогоор үйлчилгээгээ үе шаттайгаар үзүүлдэг.
5	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг үндэсний сүлжээ	– Сэтгэл зүйн үйлчилгээ, засал	– Холбон зуучлах
6	Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ	– Гэр худалдан авч өгөх	– Холбон зуучлах
7	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	– Өмгөөллийн үйлчилгээ – Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ – Эрүүл мэндийн үйлчилгээ – Боловсролыг тасралтгүй хөгжүүлэх үйлчилгээ – Орон гэртэй болоход дэмжлэг үзүүлэх	– Хохирогчийг хүлээн авна – Бүртгэл хөтөлнө. Үйлчлүүлэгчдээ файл үүсгэнэ.
8	Лантуу дохио ТББ	– Хамгаалан байрлуулах – Сэтгэл зүйн зөвлөгөө – Боловсролын үйлчилгээ – Нийгмийн ажил үйлчилгээ – Эрүүл мэндийн үйлчилгээ	– Илрүүлэх – Нөхцөл байдлыг үнэлгээ – гэр бүлд нэгтгэх
9	Талита Ази	– Хамгаалах байранд байрлуулах – Нийгэм сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ	– Кейс менежмент
10	Хүйсийн Тэгш Эрхийн Төв	– Анхан шатны туслалцаа – Нөхөн сэргээх үйлчилгээ – Эх оронд эргүүлэн авчрах – 2 төрлийн хамгаалах байр	– Илрүүлэх – Эргэн нийгэмшүүлэх хөтөлбөр – Холбон зуучлах – Гэр бүлд нэгтгэх
11	ГССҮТ-НЦҮТ	– 24-72 цаг байрлуулдаг.	– Хохирогч ирлээ шүүх эмнэлэгт хандаад гэмтлийн гаралтай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээд хорооны хамтарсан багийг дууддаг. – Хорооны хамтарсан багийн ирээд уулздаг. – Нөхцөл байдлын үнэлгээ хийдэг. – Холбон зуучлах
12	Өмнөговь аймгийн Түр хамгаалах байр	– Сэтгэл зүйн зөвлөгөө – Эрх зүйн зөвлөгөө – Нийгмийн халамжийн	– Илрүүлэх үйлчилгээ – Нөхцөл байдлын үнэлгээ – Холбон зуучлах
13	Дорноговь аймгийн Түр хамгаалах байр	– Сэтгэл зүйн зөвлөгөө – Нийгмийн халамжийн үйлчилгээ	– Илрүүлэх үйлчилгээ – Нөхцөл байдлын үнэлгээ – Холбон зуучлах
14	НҮБ-ын ОУШХБ	– Олон улсын байгууллагын баримталдаг баримт бичгийг ашигладаг. – Эх нутагт нь эргүүлэн авчрах, буцаах үйлчилгээ – Эргэн амжилттай суурьших хөтөлбөрт хамруулдаг. – Тэтгэлэг олгодог	– Илрүүлэх үйлчилгээ – Нөхцөл байдлын үнэлгээ – Холбон зуучлах
15	ЭКПАТ Монгол Үндэсний сүлжээ	– Зөвлөгөө өгөх – Сургалтад хамруулах – Дэмжих бүлэг хичээллүүлэх	– Илрүүлэх үйлчилгээ – Нөхцөл байдлын үнэлгээ – Холбон зуучлах

Зураг 22. Хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй зураглал¹⁴⁹



149 Дэлхийн зөн Монгол ОУБ-ын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ.,2021

ХАВСРАЛТ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ХОХИРОГЧ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛЧИЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН АКТУУД

№	Журмын нэр	Хэн батлах	Батлагдсан эсэх
1.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам	УЕП, ХЗДХЯ	2017оны 02 дугаар сарын 09-ны А/22, А/31 тоот тушаалаар баталсан.
2.	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.01.31-ний А/25 тоот тушаалын I дүгээр хавсралтаар баталсан.
3.	Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.01.31-ний А/25 тоот тушаалын I дүгээр хавсралтаар баталсан.
4.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.02.06-ны А/29 тоот тушаалаар баталсан
5.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам	ХНХЯ	ХНХС-ын 2020.06.26-ны А/148 дугаар тушаалаар баталсан
6.	Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам	ХНХЯ	ХНХС-ын 2017.04.20-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан.
7.	Аюулын зэргийн үнэлгээ хийх журам	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.02.14-ний А/37 тоот тушаалаар баталсан.
8.	Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.02.14-ний А/38 тоот тушаалаар баталсан.
9.	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.02.14-ний А/39 тоот тушаалаар баталсан.
10.	Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам	ХЗДХЯ ХНХЯ	ХЗДХС, ХНХС-ын 2017.03.13-ны өдрийн А/56, А/35 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
11.	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журам	ХЗДХЯ ХНХЯ ЭМЯ	ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.03.22-ны өдрийн А/63, А/48, А/106 дугаар хамтарсан тушаалаар баталсан
12.	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.04.04-ний А/73 тоот тушаалаар баталсан.
13.	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам		

14.	Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх журам	ХНХЯ	ХНХС-ын 2017.04.20-ны өдрийн А/74 дугаар тушаалаар баталсан.
15.	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам	ХЗДХЯ ХНХЯ ЭМЯ	ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.04.06-ний өдрийн А/80, А/60, А/132 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
16.	Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам	ХЗДХЯ ХНХЯ ЭМЯ	ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.04.06-ний өдрийн А/84, А/54, А/130 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
17.	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам	ХНХЯ	ХНХС-ын 2017.06.23-ний А/116 дугаар тушаалаар баталсан
18.	Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам	ЭМЯ	ЭМС-ын 2017.10.12-ний А/394 дугаар тушаалын 1, 2, 3-р хавсралтаар баталсан
19.	Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам		
20.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн тусламжийн үйлчилгээ, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам		
21.	Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам	ХНХЯ ХЗДХЯ	ХНХС, ХЗДХС-ын 2017.07.04-ны өдрийн А/120, А/178 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
22.	Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам	ХНХЯ ХЗДХЯ ЭМЯ	ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.10.04 А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
23.	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам	НХХЯ	НХХС-ын 2020.06.26-ны өдрийн А/150 дугаар тушаалаар баталсан.
24.	Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS6040:2019)	ХЗДХЯ Стандарт, хэмжил зүйн газар	
25.	Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам	БСШУСЯ	БСШУСС-ын 2018 оны А/239 дугаар тушаалаар батлагдсан.
26.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам		БСШУСС-ын 2018 оны А/612 дугаар тушаалаар батлагдсан.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ТҮҮТЭЙ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах,... мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг Хүн худалдаалах гэмт хэрэг гэнэ.	Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан үйлдлийг Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг гэнэ.
Зорилго/Purpose	
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор	
Үйлдлийн арга/Mean	
<ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэх • хүч хэрэглэхээр заналхийлэх • хулгайлах • хууран мэхлэх • итгэл эвдэх • эрх мэдлээ урвуулах • эмзэг байдлыг нь далимдуулах • хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах 	<ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэх • хүч хэрэглэхээр заналхийлэх • эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулах
Үйлдэл/Act	
Элсүүлэх Тээвэрлэх Орогнуулах Дамжуулах Хүлээн авах	Бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулах
Хүн худалдаалах гэмт хэргийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс ялгахдаа Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “зорчих эрхийг хязгаарлахгүй” байх шинжийг тогтоох шаардлагатай юм.	

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйл Албадан хөдөлмөрлүүлэх
... албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг Хүн худалдаалах гэмт хэрэг гэнэ.	Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн үйлдлийг Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг гэнэ.

Зорилго/Purpose	
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор	
Үйлдлийн арга/Means	
<ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэх • хүч хэрэглэхээр заналхийлэх • хулгайлах • хууран мэхлэх • итгэл эвдэх • эрх мэдлээ урвуулах • эмзэг байдлыг нь далимдуулах • хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах 	<ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэх • хүч хэрэглэхээр заналхийлэх • илт хохиролтой болзол, нөхцөл тулгах • хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулах • эрхшээлдээ оруулах
Үйлдэл/Act	
Элсүүлэх Тээвэрлэх Орогнуулах Дамжуулах Хүлээн авах	Цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлэх
<p>Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцохоор заасан. Гэвч тус заалтын зүйлчлэлийн агуулга нь Эрүүгийн хуулийн 13.1 ХХГХ-т заасан хүн худалдаалах гэмт хэргийн албадан хөдөлмөрлүүлж мөлжих үйлдлийн шинжтэй давхцаж байдаг.</p>	

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйл Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах
... эд, эрхтнийг авах, ... мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг Хүн худалдаалах гэмт хэрэг гэнэ.	Хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж хүний цус, эс, эд, эрхтнийг авсан үйлдлийг Хүний цус, эс, эд эрхтнийг хууль бусаар авах гэмт хэрэг гэнэ.
Зорилго/Purpose	
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор	
Үйлдлийн арга/Means	
<ul style="list-style-type: none"> - хүч хэрэглэх - хүч хэрэглэхээр заналхийлэх - хулгайлах - хууран мэхлэх - итгэл эвдэх - эрх мэдлээ урвуулах - эмзэг байдлыг нь далимдуулах - хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах 	<ul style="list-style-type: none"> - хуурч мэхлэх - хүч хэрэглэх - хүч хэрэглэхээр заналхийлэх

Үйлдэл/Act	
Элсүүлэх Тээвэрлэх Орогнуулах Дамжуулах Хүлээн авах	Хүний цус, эс, эд, эрхтнийг авах
<p>Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг заахдаа “хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүний цусыг, эсийг, эд, эрхтнийг авсан” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан боловч энэ нь ХХГХ-ийн “...хүний эд, эрхтнийг авах...” үйлдлийг мөн хамарсан байна.</p>	

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 16.4 дүгээр зүйл Хүүхдээр гуйлга гуйлгах
<p>...боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, ... албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.</p>	<p>Хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж байнга гуйлга гуйлгасан үйлдлийг Хүүхдээр гуйлга гуйлгах гэмт хэрэг гэнэ.</p>
Зорилго/Purpose	
<p>Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор</p>	
Үйлдлийн арга/Means	
<ul style="list-style-type: none"> - хүч хэрэглэх - хүч хэрэглэхээр заналхийлэх - хулгайлах - хууран мэхлэх - итгэл эвдэх - эрх мэдлээ урвуулах - эмзэг байдлыг нь далимдуулах - хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах 	<ul style="list-style-type: none"> - хуурч мэхлэх - хүүхдэд амлалт өгөх - хүч хэрэглэх - хүч хэрэглэхээр заналхийлэх - хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулах
Үйлдэл/Act	
<p>Элсүүлэх Тээвэрлэх Орогнуулах Дамжуулах Хүлээн авах</p>	<p>Байнга гуйлга гуйлгасан</p>

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 16.6 дугаар зүйл Хүүхэд худалдах
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.	Төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан үйлдлийг Хүүхэд худалдах гэмт хэрэг гэнэ.
Зорилго/Purpose	
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор	
Үйлдлийн арга/Means	
<ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэх • хүч хэрэглэхээр заналхийлэх <ul style="list-style-type: none"> - хулгайлах - хууран мэхлэх - итгэл эвдэх - эрх мэдлээ урвуулах - эмзэг байдлыг нь далимдуулах - хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах 	
Үйлдэл/Act	
Элсүүлэх Тээвэрлэх Орогнуулах Дамжуулах Хүлээн авах	Бусдад худалдах

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйл Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, ... мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.	Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон үйлдлийг Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг гэнэ.
Зорилго/Purpose	
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор	

Үйлдлийн арга/Means	
<ul style="list-style-type: none"> - хүч хэрэглэх - хүч хэрэглэхээр заналхийлэх - хулгайлах - хууран мэхлэх - итгэл эвдэх - эрх мэдлээ урвуулах - эмзэг байдлыг нь далимдуулах - хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах 	
Үйлдэл/Act	
Элсүүлэх Тээвэрлэх Орогнуулах Дамжуулах Хүлээн авах	зориуд үзүүлэх, зориуд өгөх, зориуд сурталчлах, зориуд хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэх, зориуд хүүхдэд биеэ үнэлэх, зориуд бэлгийн харьцаанд орохыг санал болгох

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 16.9 дүгээр зүйл Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, ... мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.	Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан үйлдлийг Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэрэг гэнэ.
Зорилго/Purpose	
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор	
Үйлдлийн арга/Means	
<ul style="list-style-type: none"> - хүч хэрэглэх - хүч хэрэглэхээр заналхийлэх - хулгайлах - хууран мэхлэх - итгэл эвдэх - эрх мэдлээ урвуулах - эмзэг байдлыг нь далимдуулах - хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах 	<ul style="list-style-type: none"> - цахим сүлжээ ашиглах
Үйлдэл/Act	
Элсүүлэх Тээвэрлэх Орогнуулах Дамжуулах Хүлээн авах	Бэлтгэх Борлуулах Тараах Хадгалах

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйл Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх
... боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, ... албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.	Хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн үйлдлийг Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг гэнэ.
Зорилго/Purpose	
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор	
Үйлдлийн арга/Means	
<ul style="list-style-type: none"> - хүч хэрэглэх - хүч хэрэглэхээр заналхийлэх - хулгайлах - хууран мэхлэх - итгэл эвдэх - эрх мэдлээ урвуулах - эмзэг байдлыг нь далимдуулах - хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах 	<ul style="list-style-type: none"> - цахим сүлжээ ашиглах
Үйлдэл/Act	
Элсүүлэх Тээвэрлэх Орогнуулах Дамжуулах Хүлээн авах	хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлэх

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖИШИГ МАЯГТ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6418:2013)-аас

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тодорхойлох жишиг асуулт

Нэг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох нийтлэг асуулт	
1.	Энэ ажлыг хэн, хаанаас, ямар байдлаар санал болгосон бэ?
2.	Тухайн ажиллах газарт ирүүлэхээр хэн нэгэн <ul style="list-style-type: none"> – хүч хэрэглэсэн үү? – хүч хэрэглэхээр заналхийлсэн үү? – эсхүл хулгайлсан уу? – эсхүл хууран мэхэлсэн үү? – эсхүл ойр дотны болон албан үүргийн хувьд холбоотой хүмүүс нь аливаа хэлбэрээр нөлөөлсөн байх магадлал бий юу?
3.	Тухайн ажлыг хийлгэхээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх зэрэг ямар нэгэн гэрээ хийсэн үү?
4.	Санал болгосноосоо өөр ажил хийхийг албадаж хийлгэсэн үү? Тийм бол ямар ажил хийхийг, ямар хэлбэрээр албадсан бэ?
5.	Ажлын хөлсөнд бэлэн мөнгө өгч байсан уу? Тийм бол ямар хэмжээний? Санал болгож байснаасаа зөрүүтэй юу?
6.	Ажил олгогч болон ажил санал болгосон хүндээ өртэй юу? Тийм бол өр яаж үүссэн, үүнийг нотлох гэрээ болон бусад баримт хийж байсан уу?
7.	Ажиллаж амьдарч буй орчноосоо гагш гарч чадаж байсан уу? Тийм бол ямар хэмжээнд?
8.	Олон нийтийн газраар явдаг байсан уу? Тийм бол хяналт тавьдаг байсан уу? Яаж?
9.	Орговол өөрт болон гэр бүл, ойр дотны хүмүүст нь хохирол учруулахаар заналхийлдэг байсан уу?
10.	Ямар нэгэн хүчирхийлэлд өртөж байсан уу? Тийм бол ямар?
11.	Мэдээлэл, харилцаа, холбооны хэрэгсэл хэрэглэх боломж байсан уу? Тийм бол ямар?
12.	Ажиллаж, амьдарч байсан нөхцөл ямар байсан бэ? Ямар нөхцөлд унтаж, хооллож байсан бэ?
13.	Хоол хүнсгүй байх, эмнэлэгийн үйлчилгээ авч чадахгүй, амралтгүй ажиллах тохиолдол гарч байсан уу? Тийм бол ямар хэмжээнд
14.	Өдөрт хэдэн цаг ажилладаг байсан бэ?
Хоёр. Хил дамнуулан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох нэмэлт онцлог асуулт	
1.	Гадаад улсад аялдахдаа ямар зорилготой байсан бэ?
2.	Гадаад улсад зорчих бичиг баримтыг хэн бүрдүүлсэн бэ?
3.	Гадаадын өөр орноор дамжсан уу?
4.	Гадаадад зорчих бичиг баримтын болон аялалын зардлыг өөрөө төлсөн үү? Үгүй бол хэн, ямар хэмжээний төлбөрийг, ямар нөхцөлтэйгөөр төлсөн бэ?
5.	Ямар боомтоор гарсан бэ?
6.	Гадаад паспорт болон бусад хувийн бичиг баримт нь өөрт нь байгаа юу? Үгүй бол яагаад?
7.	Гадаад паспорт болон бусад бичиг баримт хуурамчаар авч байсан уу?

НОМ ЗҮЙ

Эрх зүйн баримт бичиг

- Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,1999, №30
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №5
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2013, №30
- Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2011, №8
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2019, №48
- Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №41
- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,1992, №1
- Стандарт, хэмжил зүйн газар, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 5852:2017) стандарт
- Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2018, №5
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам
- Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаал “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх” журам
- Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2021, №31
- Хууль зүйн сайдын 2014 оны А/112, А/113, А/114 дүгээр тушаал, Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 дүгээр тушаал
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2012, №7
- Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, 2017
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, 2017.
- Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016, №9
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016, №21
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017, №3
- Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2013 оны 462-р тушаал “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх” журам

Судалгааны тайлан

- Азийн сан “Монголын уурхайн газар дах биеэ үнэлэлт ба хүний наймаа” судалгаа, 2008 он
- Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, Судалгааны тайлан, 2022
- АНУ-ын төрийн департамент, 2018 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан
- АНУ-ын төрийн департамент, 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан
- АНУ-ын төрийн департамент, 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан
- АНУ-ын төрийн департамент, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан
- Дэлхийн зөн Монгол ОУБ-ын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, 2021
- НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, УБ.,2021

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа, 2018

Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк, Ядуурлын дүр төрх, 2021

Үндэсний статистикийн хороо, Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017

ХЗДХЯ, Азийн сан, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдыг чадавхыг үнэлэх судалгааны тайлан, 2017

Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал” тайлан, 2010

Хүйсийн тэгш эрхийн төв, ТББ, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал судалгааны тайлан, 2021

Ном, гарын авлага, илтгэл, өгүүлэл

Б.Өнөрмаа, Ялгаварлан гадуурхалтын ойлголт, эрх зүйн зохицуулалт

Г.Түмэннаст, Боловсролын тэгш бус байдал ардчиллын өөрийнх нь хувь заяатай холбоотой асуудал

Жендэрийн үндэсний хороо, «Жендэр ба бодлого төлөвлөлт» Модуль сургалт 1-Жендэрийн сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ.,2018

Жендэрийн үндэсний хороо, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргазүйн зөвлөмж, УБ.,2020

С.Энхчимэг, Үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэг, ялангуяа хүн худалдахын эдийн засгийн логик, зах зээл хоорондын онцлог

Хүүхдийг Ивээх Сан, Хамтарсан багийн гишүүдэд зориулсан гарын авлага, УБ.,2016

Цахим хуудас

1. <http://mfa.gov.mn>
2. <https://iaac.mn>
3. <https://nhrcm.gov.mn>
4. <https://mn.usembassy.gov>
5. <https://tbinternet.ohchr.org>
6. <https://www.humanrightscareers.com>
7. <https://www.ilo.org>
8. <https://www.mei.edu>
9. <https://www.ncge.gov.mn>
10. <https://www.unfpa.org>
11. <https://www.unodc.org>
12. <https://www.who.int>
13. www.1212.mn
14. www.new.shuukh.mn
15. www.upr-mongol.mn

Гадаад хэл дээрх эх сурвалж

United Nations Children’s Fund, A Familiar Face: Violence in the lives of children and adolescents, UNICEF, New York, 2017.



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361
✉ Mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn
📘 Save the Children in Mongolia
🐦 Save the Children MN
📺 HairaarUlgerley